



1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Ерөнхий мэдээлэл

Хонгорын хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Сэнтурия монгу” ХХК-н эзэмшилт байсныг Кадастрын хэлтэсийн даргын 774 тоот шийдвэрийг үндэслэн 2018 оны 11-р сарын 07-ны өдөр “Мин Ли Да” ХХК нь өөрийн нэр дээр шилжүүлэн авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн талбай нь 2033.04.28 өдөр хүртэл хүчинтэй. “Хонгорын хайлуур жоншны орд” нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас баруун урагш 13 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км, Айраг сумаас баруун хойш 26км-т нарт багийн нутагт оршдог. Уг талбай нь үндсэндээ “Хонгор” гэж нэрлэгддэг бөгөөд В.М.Садыков 1980 онд нөөцийг удирдан Зөвлөлт Монголын Эрдэм шинжилгээний хамтарсан экспедицийн хээрийн судалгааны ажлаар нээж илрүүлэн Хонгорын бүлэг ордын нөөцийг батлуулсан. Хонгор овоо нэртэй нийт 112 га талбайд 5692А ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх 2003 оны 04 сарын 28 өдөр “Өсөн”ХХК-д тухайн үеийн АМГТХЭГазрын даргын тушаалаар олгосон.

Тус ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-г “Сэнтурия монгу” ХХК-ийн захиалгаар “Эрдэнэс инженеринг” ХХК 2018 онд боловсруулсан. Тус ТЭЗҮ-г жилд 30.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар боловсруулж 2018.09.07 –ны өдөр АМГТГ-ын даргын Т/105 тоот тушаалаар ТЭЗҮ-г хүлээлгэн өгсөн. Харин “Мин ли да” ХХК нь тус ордыг ил болон далд аргаар олборлох ТЭЗҮ-г “Эрдэнэс инженеринг” ХХК –иар боловсруулан батлуулсан байна. Тус уурхай нь 2020, 2021,2022 онуудад COVID-19 цар тахалын улмаас үйл ажиллагаа явуулаагүй болно.

2021 онд “Хил хизгааргүй алхам” төрийн бус байгууллагаас “Мин Ли Да” ХХК-д Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг хийх төслийн санал ирүүлсэнийг хүлээн авч хэрэгжүүлж эхэлсэн. Тус мониторингийг “Хил хизгааргүй алхам” төрийн бус байгууллага, Айраг сумын Засаг даргын тамгын газар, Айраг сумын “Нард ” багийн малчин иргэдийн төлөөлөлтэй хамтран ургамалан бүрхэвч дээр хийж байгаа болно.

ХОБОМ-г хэрэгжүүлсэнээр иргэд, уул уурхай, Сум орон нутгын удирдлагууд өөр өөрсдийн үзэл бодол санал хүсэлт дүгнэлттэй байдаг байсан бол хамтдаа ил тодоор бодитойгоор баримтыг хамтдаа олж тогтоож нэгдсэн нэг ойлготтой болох ба хэрэв үл ойлголцол үүсвэл хөндлөнгийн төрийн бус байгууллагын тусламжтайгаар нэг цэгт хүрч ойлголцож байгаа нь энэ төслийн үр дүн гэж харж байна.

Энэхүү хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

“Мин ли да” ХХК нь 2018 онд гадаад худалдаа, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлтэйгээр байгуулагдсан болно.



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

Төслийн нэр: Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жоншны орд” –ыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж, Байгууллагын нэр “Мин Ли Да” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019088009

Регистрийн дугаар: 6302513

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дорноговь аймаг, Айраг сум, 4-р баг, Цагаан дөрвөлж, “ЗЦБЭ” ХХК-ийн байр Утас: 976-80330777

Төслийн товч тодорхойлолт: Хонгорын хайлуур жоншны ордод эхний жилд 975.4тн ФК-85 маркийн бүхэллэг жонш, 2-3 дахь жилд 1500 тн ФК-85 маркийн бүхэллэг жонш ялган БНХАУ-д борлуулахаар, харин олон овоод байрлах боловсруулах үйлдвэрт эхний жилд 29.85%-ийн агуулга бүхий 18.5мян.тн жонш, 2-3 дахь жилд 29.85%-29.91% -ийн агуулга бүхий 28.5 мян.тн жонш борлуулхаар тооцоог гаргаж төсөлд тусгасан. “Хонгор-1” –ийн хайлуур жоншны хүдрийн ордыг ил аргаар жилд дундажаар 180.0 хүртэл мян.м³ хөрс хуулж, 30.0 мян.тн хүдэр олборлох чадалтай байхаар тооцсон.

Хонгорын хайлуур жоншны ордын ашиглалтын нийт хугацаанд 79.5 мян.м³ буюу 75533.5тн жонш олборлож 479.8м³ хөрс хуулалтын ажил хийнэ.

Төслийн зорилго: Энэхүү төслийн зорилго нь тус ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ил болон далд аргаар олборлолт явуулахад оршино.

Төсөл хэрэгжих үе шат: MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 3 жилийн хугацаанд ашиглана.

1.2.Хонгорын хайлуур жоншны ордын уул-техникийн нөхцөл

Хонгорын орд нь баруун хойноос зүүн урагш чиглэлтэй судал хэлбэрийн хүдрийн биетүүдээс бүрддэг.

Тус ордын үлдэгдэл үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор ордоос олборлох нөөц нь 79,5 мянтн 32.6%-ийн агуулга бүхий хайлуур хайлуур жоншны хүдэр, нийт хуулах хөрсний хэмжээ 479.8 мян.м³ хөрс хуулалтын дундаж коэффициент 6.0 м³/тн болно. Тус “Хонгор-1”-ийн ордыг ил аргаар жилдээ 180.0 хүртэл мян.м³ хөрс хуулж, 30.0 мян.тн хүдэр олборлох чадалтай байхаар тооцсон бөгөөд нийт 30 хүн ажиллуулж, 2 ээлжийн системтэй бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг, жилд 150 хоног ажиллана. 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар тэсэлгээний ажилд Хятад улсад үйлдвэрлэсэн УТ-28 маркын гар перфоратор сонгосон байна. Энэхүү гар өрөм нь малталтуудад болон хүдэр нураалтанд бүгдэд нь хэрэглэж болдгоороо бусад өрмийн машинуудаас давуу талтай байдаг байна.



Бүс нутгийн хэмжээнд говийн их мужид байрладаг. Талбайд цав толгодлог, ухаа гүвээт рельеф зонхилох бөгөөд үнэмлэхүй өндөр 1158.6-1311.8м, харьцангуй өндөр 30-50м хүрнэ.

Хонгор-1.2-н хүдрийн биетүүдийн байх бөгөөд хүдрийн биетийн урт нь 200-350м хүртэл сунаж тогтсон. Хүдрийн биет нь балансын болон балансын бус С нөөцийн хувьд гадаргуугаас 60 гаруй метр гүн үргэлжлнэ.

Эдийн засгийн хувьд үр ашигтай байдлыг бодолцон Хонгор 1-г далд уурхайн аргаар, Хонгор 2-г ил уурхайн аргаар олборлохоор төсөлийг боловсруулсан.

Хонгорын хайлуур жоншны ордод нэвтэрсэн уул өрөмдлөгийн ажлын үед 536.0м хүртэл гүнд ус агуулагч давхарга илрээгүй нь ордыг ашиглах үед ямар нэг сөрөг нөлөөгүй олборлолтын таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Ижил төрлийн бусад ордтой харьцуулбал Хонгорын хайлуур жоншны ордын ерөнхий суурь усжилт нь нийт талбайн хэмжээнд маш бага, туйлын хязгаарлагдмал учраас ордын олборлох үед уул-технологийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хүндрэлгүй юм.

1.3.Төслийн байршил

Хонгорын хайлуур жоншны орд нь Дорноговь аймагийн Айраг сумын нутөг дэвсгэрт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 320км, Айраг сумаас баруун хойш 26км, Даланжаргалан сумын төвөөс баруун урагш 13км зайд оршдог. Талбайн хэмжээ: 112 гектар, Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49-9

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Д/д	Өргөрөг			Уртраг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	45	48	11.62	109	02	16.73
2	45	48	11.62	109	00	31.73
3	45	48	27.62	109	00	31.73
4	45	48	27.62	109	02	16.73

1.4. Ордын нөөцийн тооцоо”

“Мин Ли Да” ХХК-ийн эзэмшил дахь МУ-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд “Ордын нөөцийг Монгол Улсын Түлш Эрчим хүчний яамны Техникийн зөвлөлийн хурын 1980 оны 11 сарын 22 өдрийн 119 тоот дүгнэлийн дагуу С1+С2 зэргийн нөөц тогтоогдсон хэсэгт нөөцийн ангиллыг Хонор-1 хэсэглэл дээр 1978 онд батлагдсан В (С1) зэргээр 33.86%-ийн агуулга бүхий 244.6 тн хүдэрт 83.06 тн эрдэс гэж ашигт малтмалын улсын тоо бүртгэлд бүртгэгдсэн” нөөцөд тулгуурлан энэхүү нөөцийн үлдэгдэл нөөцөд тулгуурлан техник эдийн засгийн үзүүлэлтийн тодотголыг боловсруулсан байна.Тус ордыг 1993-ээд оноос хойш ил болон далд малтмалаар



ашигласаар ирсэн бөгөөд одоогийн байдлаар Хонгор-1 хэсэглэл дээр 1978 онд батлагдсан В (С1) ЗЭРГЭЭР 33,86%-ийн агуулга бүхий 244.6 тн хүдэрт 83.06 тн эрдэс байна гэсэн тооцоо гарсан байдаг.

Таазны хаягдал: Хүдрийн блок тус бүрд таазанд 3м зузаантай, хамгаалалтын цул үлдээх ба нийт нөөцийн 14.74% буюу 11150.8 тн хүдэр хаягдахаар тооцсон байна.

Бохирдол: Хүдэр олборлолтын явцад хүдрийн биетийн ул таазнаас тус бүр 0.1 м зузаантайгаар бохирдуулж авна. Ингэхэд ашиглалтын үеийн бохирдол нь 3882.6 тн буюу нийт нөөцийн 5.13% болно гэж 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан байна.

1.5.Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор хөрс хуулалтын коэффициент $K_{х,х}=6.0 \text{ м}^3/\text{тн}$ болж байна. Иймээс хонгорын хайлуур жоншны уурхай нь нийт 3 жилийн хугацаанд жилд дундажаар 30.0 мян.тн хүдэр олборлож, дундажаар 180.0 мян.м^3 хөрс хуулах хүчин чадалтай байхаар уулын ажлын календарчинлсан төлөвлөгөөг боловсруулсан. Далд уурхайн ажиллах горимыг “Монгол улсын хөдөлмөрийн хууль”-ийн дагуу ажиллахаар төсөлд тусгасан.Төсөл хэрэгжүүлэгчээр ТЭЗҮ боловсруулах даалгаварт өгсөний дагуу жилд дундажаар 20.0-30.0 мян.тн хүдэр олборлон борлуулах хүчин чадалтай.

Уурхайн жилийн хүчин чадал:

Хонгорын хайлуур жоншны уурхайн жилийн хүчин чадалыг уул техникийн нөхцөл болон уурхайн жилд хуулах хөрсний хэмжээ, үйлдвэрлэлийн нөөц, ажиллах хугацаа, техник технологийн нөхцөл зэрэгт тулгуурлан уурхайн хүчин чадалыг төсөл захиалагч компани техникийн даалгаварын дагуу эхний жилд 20.0 мян.тн , 2-3 жилд 30.0 мян.тн хүдэр олборлон борлуулхаар төсөлд тусгасан.

$$A_{х,х}^* = A_0^* \times K_{х,х} = 30000 \times 6.0 = 180.0 \text{ мян.м}^3/\text{жил}$$

Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөлт

	Ашиглалтын түвшин	Ашиглах хүдэр		Дундаж агуулга.%	Эрдэсийн хэмжээ. тн	Хуулах хөрс. М^3
		М^3	тн			
Эхний жил	1232	2646.3	7250.8	32.6	2364.5	117053.8
	1230	3188.9	8737.5	32.6	2849.3	
	1225	1284.9	3520.7	32.6	1147.6	
	Нийт	7120.1	19509.0		6361.4	117053.8
Хоёр дах жил	1230	1551.1	4250.0	32.6	1385.9	180318.9
	1225	3585.8	9825.1	32.6	3202.5	
	1220	4546.4	12457.2	32.6	4062.3	
	1215	1265.6	3467.8	32.7	1132.6	
	Нийт	10948.9	30000		9783.4	
Гурав дах	1215	2723.3	7461.9	32.7	2437.2	
	1210	2747.3	7527.6	32.7	2463.1	



	1205	2266.6	6209.0	32.6	2024.8	182417.5
	1200	1415.6	3878.9	32.7	1266.9	
	1195	1198.1	3282.8	32.6	1070.5	
	1190	598.5	1639.9	32.7	536.6	
	Нийт	10948.9	30000		9799.1	182417.5

Тус уурхайн ажиллах горимын хувьд тасралтгүй ажиллагаатай байх ба баяр ёслолын болон амралтын үед ажилчидын амрах хугацааг Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн дагуу уурхайн даргын тушаалаар зохицуулна. Мөн бүс нутгийн цаг агаарын онцлог, уул тээврийн тоног төхөөрөмжүүдийн ажлын бэлэн байдал, тэдгээрийн техникийн нөхцөл боломжуудаас хамааруулан тооцно. Иймээс уурхай үндсэн 2 ээлжээр, нэг ээлжинд 12 цагаар ажиллана. $N_{ж}=365-(N_{б}+N_{ц.а}+N_{з.ү}+N_{з.н})$

Хүснэгт 4. Далд уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөлт

№	Ашиглалтын блокын дугаар	Нөөцийн зэрэг	Хүдрийн хэмжээ м ³	Хүдрийн хэмжээ тн	Дундаж агуулга,%	Эрдэс тн
1	101	В	6248.2	17120.2	32.19	5511.7
2	102		7025.4	19249.7	31.92	6144.4
3	103		1861.5	5100.6	30.99	1580.7
4	104		5915.6	16208.7	33.43	5418.4
5	105		3911.2	10716.7	32.11	3441.4
НИЙТ			24962.3	68396.0	32.31	22096.6

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим ба хугацаа

Д/д	Ажиллах горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Ажиллах горим	-	тасралтгүй
2	Ээлжийн тоо	-	2
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа	мин	720
4	Хоногт ажиллах хугацаа	мин	1140
5	Ээлжин дэх амралтын ба завсарлах хугацаа	мин	60
6	Ээлжийн бэлтгэл төсгөл хугацаа	мин	20
7	Бүтээлтэй ажиллах хугацаа	мин	640
8	Жилийн хуанлийн хоног	мин	365
9	Баяр ёслолын хугацаа	хоног	$N_{б}$ 11
10	Цаг агаараас шалтгаалж зогсох хугацаа	хоног	$N_{ц.а}$ 20
11	Засвар үйлчилгээний хугацаа	хоног	$N_{з.ү}$ 32
12	Хөрс хуулах хугацаа	хоног	302
13	Хүдэр олборлох хугацаа	хоног	290

Хүснэгт 5. Нэг ээлжийн ажиллах ажлын цикл



Үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт/мин
Ээлжийн үргэлжлэх хугацаа/мин/							720						720
Ээлжин дэх амралтын ба завсарлах хугацаа							60						60
Ээлжийн бэлтгэл төгсгөл/мин/	10											10	20
Ээлжинд цэвэр ажиллах хугацаа/мин/					320					320			640
Ээлжийн цаг ашиглалтын итгэлцүүр $K_{ц.а}$	0.85												

Өрөмдлөг тэсэлгээний ажил

Тэсэлгээний ажлыг “ФООР БЛАСТ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх бөгөөд өрмийн төхөөрөмжийн ажиллах талбайг засаж тэгшлэх, бэлтгэх төхөөрөмж ба туслах тоноглолыг ажилд бэлтгэх, цахилгаан эрчим хүч, өрмийн багаж төхөөрөмж бусад материалаар хангах, өрөмдсөн цооногуудыг эвдрэлтээс хамгаалах, бүртгэл, хэрэгжилт, төхөөрөмийн зөөвөр нүүдэл, засвар цахилгааны шугамын өөрчлөлт зэрэг олон туслах ажлууд байна.

Доголын талбайг өрөмдлөгт бэлтгэхдээ талбайд буй саад болох төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлыг долдуу бульдозер хэрэглэж гүйцэтгэнэ. Засаж бэлтгэсэн талбайд маркшейдерийн хэмжилтээр цооног байрлах тэмдэглэгээг хийх ба цахилгаан, шахсан агаар хангах өрөмдөх төхөөрөмжөө байрлуулж ажилд бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Өрөмдлөгийн паспортоор цооног бүрийн байршил, гүний хэмжээг тогтооно. Хяналтын хэмжилтээр ажлын хэрэгжилийг тодорхойлох ба өрөмдлөг торны зай, гүний зөрүү нь 0.3 м-с хэтрэхгүй байх ёстой. Цооног янз бүрийн учир шалтгаанаар нурж гүн нь хорогдох, цасаар дүүрэх, ус тогтох мөстөх зэрэг тохиолдолд дахин өрөмдлөг хийж засварлана. Эдгээр ажлыг багасгахын тулд өрөмдөгдсөн цооногийн шилжих нөөцийг (тэслэгдээгүй үлдэх) багасгах хэрэгтэй.

1.6. Ордыг нээх ба ашиглах дараалал

Уурхайг нээх ил уурхайн нээлтийн хувьд гадаад траншей нэвтэрч хөрс, хүдрийн доголдуудыг нээх ба ашиглалт, олборлолтын үеийн доголын өндөр 12 метр байна.

Мөн дараагийн түвшин, доголдуудыг дотоод трайншейгаар нээх замаар ил уурхайн тэлэлт, гүнзгийрүүлэлтийн ажлуудыг үргэлжлүүлнэ. Нээгч траншейн эзлэхүүнийг дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 6. Нээгч траншейн үндсэн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Эзлэхүүн	Метр.куб	1956.3
2	Траншейн дагуух налууугийн	0/00	80
3	Траншейн хажуугийн налууугийн өнцөг	градус	60-70
	өргөн		10



4	Траншейн дундаж	урт	метр	63
		өндөр		5

Ордын хүдрийн биетийн тогтоц ордын уул-техникийн нөхцөлөөс хамааруулан гадаад овоолгод тээвэрлэх авто тээвэргүй, ашиглалтын системээр ашиглахаар өмнөх төсөлд тусгасаж тооцсоныг цаашид үргэлжлүүлэн явах боломжтой гэж үзэн төсөлд тусгасан. Ашиглалтын технологийн схемийг дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 7. Ил уурхайн ашиглалт технологи

Ашиглалтын технологи	Ил уурхайн үндсэн ажил	Ашиглалтын технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Өрөмдлөг тэсэлгээ
		Ухаж ачих
		Тээвэрлэх
	Хүдэр олборлолт	Өрөмдлөг тэсэлгээ
		Ухаж ачих
		Тээвэрлэх
		Овоолох

Ордыг уул техник, уул геологийн нөхцөл, хүдрийн биетийн зузаан, хөрс ба хүдрийн хатуулаг, уулын үндсэн техник төхөөрөмжийн хүчин чадал зэргээс хамааруулан уурхайн хөрс болон хүдэр олборлолтын ажлын доголын өндрийг 12 м байхаар тооцов. Ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголыг аюулгүйн дүрмийн дагуу ажлын 3 доголыг нэгтгэж болох боловч бид ажлын 2 доголыг нэгтгэж ажлын бус доголын өндөр 24 м байхаар тооцсон. Авто замын өргөн тооцоогоор 20 метр байхаар тус тус тооцоолсон. Ажлын талбай нь тухайн догол бүрд хэрэгжүүлэх технологийн процессуудыг явуулах орон зайн нөхцөлийг хангахаар зориулагдсан байна. Тэсэлгээний нурал, тээврийн аюулгүй зай, техникийн ажиллах нөхцөл зэргийг тооцож үзэхэд ажлын талбайн хамгийн бага өргөн 35м байна.

Хүснэгт 8. Ил уурхайн үндсэн хэмжээс

Д/д	Үзүүлэлт	Тэмдэглэгээ	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Өрөмдлөг, тэсэлгээний ажлын доголын өндөр	Над	метр	5.0
2	Хөрс хуулалтын доголын өндөр	Нххд	метр	5.0
3	Хүдэр олборлолтын доголын өндөр	Нход	метр	5.0
4	Ажлын доголын аюулгүйн өргөн	b	метр	3.0
5	Ажлын доголын хажуугийн өнцөг	Ө	градус	65
6	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	β	градус	55
7	Ажлын талбайн хамгийн бага өргөн	B	метр	35
8	Уурхайн хажуугийн ерөнхий налуу	α	градус	51
9	Ил уурхайн траншей, авто замын өргөн	r	метр	10
10	Траншей болон авто замын налуу	i	промил	80



Шимт хөрс хуулалт: Ордын хөрсний чулуулаг нь дээд хэсгээрээ буюу 0.2-0.5 метр гүн хүртэл өгөршилт автагдсан сэвсгэр хурдаснаас, доод хэсгээрээ хатуу чулдуулгаас тогтоно. Шимт хэрсийг хуулахдаа 0.2-0.5 метрийн зузаанаар бульдозероор түрж овоолго үүсгэн утгуурт ачигчаар автосамосвалд ачиж уурхайн олборлолтын талбайн гадна удаан хугацаанд хадгалах овоолгод зөвөөрлөж хадгална. Үржил шимт хөрсийг уурхайн нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглана.

Үндсэн хуулалтын ажил: тус уурхайн үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь 8-14 зэрэглэлд хамаарна. Хөрсний чулуулгийг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэх ба экскаватор автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэн овоолго үүсгэнэ. Хөрс хуулалтын ажлын догол нь 5 м өндөртэй байна. Хөрс хуулалтын ажилд 4м³-ын утгуурын багтаамжтай гидравлик экскаватор ажиллана.

Хүдэр олборлолт: хөрсний доголтой нэгэн адил хүдэр олборлолтын догол нь мөн 5 м өндөртэй байна. Хүдэр олборлолтын ажилд 4.0 м³ –ын утгуурын багтаамжтай гидравлик экскаватор ажиллана. Автосамосвалууд нь хөрс, хүдэр тээвэрлэлтэнд ажиллах хосолмол ажиллагаатай байна. Ингэснээр автосамосвалуудыг хөрс, хүдэр аль алинд нь ашиглах боломжтой юм. Үүний үр дүнд ачаа тээвэрлэлтийн бүтээмж сайжирч автосамосвалууд нь хөрс, хүдэрт солбиж ажиллуулах сайн талтай. Мөн аль нэг тээвэрт явж байгаа автосамосвал засвар үйлчилгээнд орсон тохиолдолд түүнийг орлож автосамосвалын ашиглалт нэмэгдэх юм. Олборлосон хүдрийг баяжуулах хэсгийн хүлээн авах бункерийн дэргэдэх хүдрийн агуулахад тээвэрлэн хүргэж овоолго байгуулна.

1.7.Ил уурхайн хөрсний овоолго

Хөрсний овоолго: овоолгын байршилын сонголтыг хийхдээ ордын нөөц, гадаргын өндөржилт, тээврийн зай, салхины чиглэл, хүдэргүйжилт зэргийг анхаарч овоолгын байршилыг ил уурхайн баруун талд байрлуулхаар сонгосон. Чулуулгын тогтворжилт, нөхөн сэргээлт хийж хэвгийжүүлэх нөхцөлийг үндэслэн овоолгын ерөнхий хэмжээсийг сонгосон. Хөрсний овоолгын үндсэн хэмжээсийг дор хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Овоолгын үндсэн хэмжээс

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	
1	Овоолгын ярусын өндөр	м	25	Хөрсний овоолго байгуулах
2	Овоолгын яруусын тоо	ш	2	
3	Овоолгын нийт өндөр	м	50	
4	Овоолгын бермийн өргөн	м	10	
5	Овоолго дахь авто замын өргөн	м	16	
6	Овоолгын замын налуу	промил	80	
7	Овоолгын эзлэх талбай	га	170.3	



1.8.Төслийн техник тоног төхөөрмж, дэд бүтэцийн хангамж, туслах материал

1.8.1. Техник тоног төхөөрөмж

Тус төслийн хүрээнд тэсэлгээний ажилд DC-726B маркийн эргэлтэт цохилтот өрмийн машин ,хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд Hyundai 2900LC маркийн урвуу утгуурт эксковотор, хөрс тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн 25тн-ын даац бүхий автосамосвалууд байхаар, уурхайн шимт хөрсний овоолгыг бөөгнүүлэх, автосамосвалд ачих, хүдрийн түр овоолго гадаад тээврийн автосамосвалууд хүдрийг ачих зэрэг ажилд ZL50 маркийн 3.0м³ шанаганы багтаамж бүхий утгуурт ачигч 1 ширхэг, овоолго түрж тараан тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэрэг техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Shantui SD23 бульдозер, уурхайн гадаад тээвэрт EURO-3 стандартын шаардлага хангасан “NORTH BENZ” маркийн нийт 25 тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай автосамосвалууд байна.

Хүснэгт 10. Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадалын тойм үзүүлэлт

№	Техникийн нэр төрөл	Техникийн марк	Тоо хэмжээ /ш/	Техникийн үзүүлэлт		
				Ажлдын багтаамж, м ³ (тн)	Хурдны дээд хязгаар км/цаг	Жилийн бүтээлийн норм, мян.м ³
1	Экскаватор	Hyundai-2900LC	1	4.0-5.5	3.1	361.3
2	Автосамосвал	HOWO	2	25	59	128.3
3	Автосамосвал	North-Benz	2	21	75	
4	Утгуурт ачигч	ZL-50	1	3.0	13.4	906.6
5	Бульдозер	Shantui SD 23	1	5.4	5.5-7.0	280.88
6	Өрмийн машин	DC-726B	1	25м/цаг		677.8

1.8.2. Тэсэлгээ тэсрэх бодис

Тэсэлгээний блокийн урт хөрсний блокд 200м, хүдрийн блокд 200м байхаар сонгон авч нэг удаагийн уулын цулын хэмжээг тооцоолбол:

Хүснэгт 11. Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцооны хүснэгт

№	Үзүүлэлт	Нэгж	DC-726 B	
			Хүдэр	Хөрс
1	Илүү өрөмдлөг	м	2.3	2.3
2	Цооногийн диаметр	мм	115	115
3	Өрөмдөж тэслэх доголын өндөр	м	5	5
4	Цооногын урт	м	7.3	7.3
5	Цооногын налууугын өнцөг	град	90	90
6	Цооногын түгжээсний урт	м	2.3	2.3
7	Цооногын цэнэгийн урт	м	5.0	5.0
8	Цэнэглэлтийн нягт	кг/м ³	1100	1100



9	1 м цооногийн цэнэгийн хэмжээ	кг	11.42	11.42
10	1 цоонгогт орох тэсрэх бодис	кг	57.1	57.1
11	Доголын налуугийн өнцөг	град	55.0	55.0
12	Улны эсэргүйцлийн шугамын	м	7.2	7
13	Доголын ирмэгээс цооног хүртэлх зөвшөөрөгдөх хэмжээ	м	2.7	2.5
14	Цооног хоорондын зай	м	6.1	6.0
15	Цооног ойртолтын коэффициент		0.85	0.85
16	Цооногуудын эгнээ хоорондлын зай	м	5.2	5.1
17	1м цооногоос гарах уулын цулын хэмжээ	M ³ /м	18.3	16.7
18	Эгнээний тоо	ш	6	5
19	Тэслэх блокын урт	м	80	60
20	Тэслэх блокын өргөн	м	32.4	27.3
21	Нэг удаагийн тэсэлгээнээс гарах уулын цулын хэмжээ	M ³	12965	8186.3
22	Нэг блокод өрөмдөх цооногийн тоо	ш	78	50
23	Нэг блокод орох тэсрэх бодисын хэмжээ	кг	4478.3	2878.9
24	Нэг блокод орох NONEL-6.0 метр	ш	78	50
25	Нэг блокод орох өдөөгч ПТ-400	ш	78	50
26	Нэг блокод орох ДША	м	576	360
27	Нэг блокод орох цахилгаан тэслүүр	м	8	8
28	Нэг блокод орох хором удаашруулагчийн тоо	ш	345	352
29	1000м ³ -д ноогдох ТБамфо+эмульс	кг	6	6
30	1000м ³ -д ноогдох nonel	ш	6	6
31	1000м ³ -д ноогдох Өдөөгч	ш	44	44
32	1000м ³ -д ноогдох ДША	м	3.9	6.1
33	1000м ³ -д ноогдох цахилгаан тэслүүр	м	0.5	0.6
34	1000м ³ -д ноогдох хором удаашруулагчийн тоо	ш	0.6	1.0

Сүүлийн үед уул уурхайн компаниуд тэсрэх бодисыг сонгохдоо энгийн тэсрэх бодис хэрэглэж байгаа бөгөөд устай нөхцөлд тэсэлгээг найдвартай байх үүднээс эмульс-анфо тэсрэх бодис хэрэглэж байна.



Хүснэгт 12.Тэсэлгээний ажлын үе дэх аюулгүй бүсийн зай

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	
			Хөрс	Хүдэр
1	Тэслэгдэх доголын улны эсэргүүцэл	м	5.04	4.90
2	Нэг агшинд тэсрэх бодисын тоо	кг	746	576
3	Тэсэлгээгээр үүсэх агаарын цохилтын урсгал хүсүүст аюултай үйлчлэх бүс	м	826.1	677
4	Ил гадарага ба цэнэгийн байршлын харьцааны нөхцөлийг тооцох коэффициент	м	12.5	12.5
5	Тэсэлгээгээр үүсэх агаарын цохилтын барилга байшинд аюултай үйлчлэх бүс	м	491.7	429
6	Чичиргээний аюултай бүс	м	147.5	128
7	Чичиргээний аюултай бүс	м	409.8	358

Хэрэв тэсэлгээний тооцоогоор чичиргээний аюултай үйлчлэх R_r радиусын хэмжээ нь бодит зайн хэмжээнээс давж байвал барилга байгууламжид чичиргээ доргио аюултай нөлөөлнө. Иймээс аюулгүйн зайн талаас нь бодож нэг удаагийн тэсэлдгээнд хамрагдах тэсрэх бодисын хэмжээг хязгаарлах арга хэмжээ авна.

Аюултай бүсүүдийн хилийг тогтоож тусгай тэмдэг байрлуулах ба тэсэлгээний өмнө харуул хамгаалалт гаргана. Тэсрэх материалыг зөөх байрлуулах цооногуудыг цэнэглэх холболтууд хийх зэрэг тэсэлгээний бэлтгэл ажлыг дүрэм журмын заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Тэсэлгээнээс өмнө аюултай бүсэд буй тоног төхөөрөмжүүдийг холдуулж аюулгүй бүсэд гаргах цахилгааны шугамыг таслах зэрэг аюулгүйн нөхцөл хангах ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Тэсэлгээг хэвшиж тогтсон өдөр цагт явуулдаг. Тэсэлгээний аюултай бүсээс хүмүүсийг гаргахын тулд анхааруулах дохио өгөх ба бүх хэлтсийн удирдлагууд болон мастеруудад мэдэгдэнэ. Уурхайнуудад ихэвчлэн дуут дохиог хэрэглэдэг. Тэсэлгээг удирдаж буй хүн бэлэн байдлыг хянаж дохио өгсөний дараа тэсэлгээчин тэсэлгээг явуулна. Тэсэлгээний дараа тэсэлгээ явагдсан блокод үзлэг хийж гацаа/бааралт/ үүссэн эсэхийг тогтооно. Тэсэлгээ хэвийн явагдсан бол дохио өгч тэсэлгээ дууссаныг мэдэгдэнэ. Хэрэв ямар нэгэн гацаа үүссэн байвал түүнийг устгах арга хэмжээ авна. Тэсэлгээ дууссан дохио өгөгдөөгүй тохиолдолд аюултай бүсэд орох үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй. Их хэмжээний тэсрэх бодис хэрэглэсэн буюу эсвэл гүн уурхайн гүний хэсэгт тэсэлгээ хийсэн бол тэсэлгээний дараах агааруулалт явагдсаны дараа тухайн бүсэд хүн ажиллаж болно.

2023 онд далд уурхайн ажиллах горим

- 1.Жилийн ажлын хоног-365
- 2.Жилд тохиолдох баяр ёслолын өдөр-11
- 3.Жилд хийх засвар үйлчилгээний өдөр -12
- 4.Жилд ажиллах хоног-342
- 5.Хоногт ажиллах ээлж-2
- 6.Ээлжийн үргэлжлэх хугацаа-8 цаг



Орд газрыг нээх

Хонгор 1-н жоншны хүдрийн биет нь дунджаар 3.9 м-ийн зузаантай 70⁰ хүртэл унасан гүнрүүгээ 40м хүртэл үргэлжлэнэ.

Далд уурхай нь +1244 түвшин дэх 5074218.661, 345419,764 цэгээс налуу гол ам нэвтрэн 10 м түвшин бүхий спиралаар +1190 түвшин хүртэл бууж уг түвшингөөс хүдрийн биет уруу штрек малтан олборлолтын ажлыг явуулж эхлэнэ.

Далд уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажил

Далд уурхайн малталт нэвтрэлт болон хүдэр нураах ажлыг өрөмдлөг, тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлж явуулна. Тусгай зориулалтын гар перфоратор ашиглаж өрөмдлөг хийж бортогон тэсрэх бодисоор цэнэглэж тэсэлнэ. Өрөмдөх нүхнүүд нь цөмлөх, нураах, хэлбэршүүлэх зориулалттай байна.

Хонгор 1-н ордын малталт нэвтрэлтийн ажил болон хүдрийн нураалтын ажилд Хятад улсад үйлдвэрлэсэн YТ-28 маркийн гар перфоратор сонгосон болно. Энэхүү гар өрөм нь малталтуудад болон хүдэр нураалтад бүгдэд нь хэргэлж болдогоороо бусад өрмийн машинаас давуу талтай. Өрөмдлөг тэсэлгээний ажилд хэрэглэх тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгсэлийг манай улсад үйлдвэрлэсэн бусад далд уурхайнуудад өргөн хэрэглэгдэж байгаа 32 мм диаметртэй, 300мм урттай бортогон эмульсийн тэсрэх бодис, нонель систем /3-5/, цахилгаан бялт тэслүүр /ЭД/ , цочир дамжуулах шижим/ ДША/, цахилгаан дамжуулах утас зэрэг тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахаар уг төсөлд тусгасан байна.

1.8.3. Дэд бүтэц,объектууд

Уурхайн авто засварын газар ба сэлбэгийн агуулах

Ил уурхайн уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд болон бусад аж ахуйн хангамж үйлчилгээний техник тоног төхөөрөмжүдийг задгай саравч бүхий зогсоолд байрлуулна. Мөн уурхайн техникүүдийг засварлах зорилгоор засварын газар/цех/ болон сэлбэг хэрэгсэлийн агуулах, авто гражуудыг уурхайн хотхоны дэргэд уурхайн хотхоноос 100 метр зайд байгуулсан. Уурхайн авто засварын газар болон сэлбэг хэрэгсэлийн агуулах нь уурхайн техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн өдөр дутамын үзлэг үйлчилгээ, урсгал засвар засварын ажилд шаардлагатай аливаа материал, сэлбэг хэрэгсэл, тос тотсолгооны материал зэргийг хүлээн авах хадгалах, засаж сэлбэх, тавьж олгох зориулалттай байна. Эдгээр барилга байгууламжууд нь галд тэсвэртэй буюу шатдаггүй сэндвичэн материалаар баригдсан барилга юм.

Тэсрэх материалын агуулах.

Тэсрэх материалын агуулахыг талбайд ил уурхай болон уурхайн тосгон зэрэг барилга байгууламж объектуудаас зайтай бариж байгуулан ашиглаж байна. Ингэхдээ уг агуулахыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” –ийн дагуу бариж байгуулан энэхүү дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тэсрэх материалын агуулах нь 25тн бүхий 2ш



контейнерэн байгууламжтай. Уурхайн жилийн хэрэглээ 65 орчим тонн тэсрэх бодис хэрэглэнэ. Иймээс агуулахын багтаамж нь уурхайн нэг сарын хэрэглээг хангаж байхаар багтаамжтай агуулах юм.

Уурхайн үйлдвэрийн цахилгаан хангамж

Хонгорын хайлуур жоншны уурхайн бүх цахилгаан хэрэглэгчдийн тооцооны нийт бүрэн ачаалал 87кВА гэж тооцоолсон. Энэхүү тооцооллын бүрэн ачаалалаас үзэхэд 125 кВА хүртэл номиналь бүрэн чадалтай хүчний нэг дизель цахилгаан станц шаардлагтай юм. Тиймээс Himoisa брэндийн HFW-125 T5 маркийн дизель цахилгаан станц хэрэглэж байсан бөгөөд 2020.01 -р сараас Даланжаргалан сумаас уурхай руу 14.3км -ийн байнгын хэрэглээний цахилгааны өндөр хүчдэл /0.35 КВТ/-ын шугамыг татаж, дэд станцын байгууламжыг барьж цахилгааны асуудлаа шийдсэн. Үүнийг барьж байгуулахад холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг хуулийн хүрээнд авч мэргэжлийн байгууллагаар хийлгэж улсын комисст хүлээлгэн өгч ашиглах эрхээ авсан. Одоогоор Чойрт байрлах цахилгаан шугам сүлжээний байгууллагатай гэрээлж эрчим хүчээ хангаж байна.

Түлш, шатах тослох материалын хангамж

Шатах тослох материалын түр агуулах болон ШТС нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрийн цогцолбороос 120 метр зайд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд байрлаж байна. ШТС нь уурхайн нэг сарын хэрэглээг хангах хэмжээний 20 тонны 1 ширхэг ёмкость бүхий ШТС юм. Уурхайн түлш шатахуун, шатах тослох материалыг “Сан петролиум” компаниудтай байгуулсан гэрээний дагуу зөөвөрлөн хангаж байна. ШТС-ыг галын аюулгүй байдлын үүднээс гал унтраах багаж хэрэгсэлээр хангаж, тэмдэг тэмдэглэгээг байршуулан тоногдсон болно.

Уурхайн удирлага болон ажилчидын хотхоны байр

Уурхайн захиргаа болон инженер техникийн ажилчидын ажиллах нөхцөлөөр хангах үүднээс уурхайн талбайд уурхайн захиргааны оффис байгуулсан ба үүнд уурхайн инженер техникийн ажилчид, санхүү эдийн засаг, уурхайн дарга, ажилчидад ажлын зааварчилгаа /наряд/ өгөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтын өрөө, эмийн сан яаралтай тусламжийн багаж хэрэгсэлийн өрөө, хурлын заал, гол тогоо, амрах байрнууд гэх мэт өрөө тасалгаатай. Төслийн эхний жилийн хүрээнд хонгорын орын олборлолт явуулах үед ажиллах хүчний хэрэгцээнд тулгуурлан уурхайн хотхоны төлөвлөлтийг урьдчилсан байдлаар хийсэн ба уурхайчдын хотхон нь нийт 30 хүний багтаамжтай ба цаашид өргөтгөх боломжтой юм.

Зам тээвэр харилцаа холбоо

Хонгорын хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших бөгөөд сумын төвөөс баруун хойш 27 км, Даланжаргалан сумаас зүүн урагш 13 км-т Улаанбаатар хотоос 320 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн бүсэд байрлаж байна.



Хүдэр тээвэрлэх зам

Уурхайн бүсээс Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах ачилтын талбай руу хүдэрийг өөрийн тээврээр тээвэрлэдэг болно.

2.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

2.1 Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд

БОНЕУ-ний дүгнэлтэд төслийн зорилго, цар хүрээ, техник, технологи, үйл ажиллагаа нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Байгаль орчныг хамгаалах” болон “Байгаль нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль тогтоомж, төр засгийн холбогдох бодлого, шийдвэртэй хэрхэн нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, төслийг хэрэгжүүлсэнээр байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоон, сөрөг нөлөөлөл үүсэж болох нөхцөл, онцгойлон анхаарах зүйлсийг тусгасан.

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Хонгорын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлын үнэлгээний тайланг үндэслэн БОАЖЯ-ын шинжээчийн 2018.10.01-нд гаргасан 2018/Т-173 тоот байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг ерөнхий шинжээч 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 13/6968 тоот албан бичгээр баталгаажуулсан байна.

Бүс нутгийн хэмжээнд говийн их мужид байрладаг. Талбайд цав толгодлог, ухаа гүвээт рельеф зонхилох бөгөөд үнэмлэхүй өндөр 1158.6-1311.8м, харьцангуй өндөр 30-50м хүрнэ. Мөн урьд онуудад олборлолтонд өртсөн “Хонгор-2” хэсгийн нөхөн сэргээлт хийх талбай нь 527м өргөнтэй, 925м урттай ил уурхайн болон овоолгын талбайнууд байна. “Хонгор -1” нөөцийн хэсэглэлийн талбайд 93.88 мян.тн хүдэр үлдсэн байна.

Энэ хүдрийн биет нь баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон судлын төрлийн биет юм. Хонгорын хайлуур жоншны ордын хүдрийн биетийн урт нь 240 м, хүдрийн биетийн нийлбэр зузаан 4-8м, гүндээ 60 хүртэл метр гүнд судлагдсан.

Тус ордын үлдэгдэл нөөцийг 3 жилийн хугацаанд ашиглах бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор ордоос олборлох нөөц нь 79.5 мян.тн 32.6%-ийн агуулга бүхий хайлуур жоншны хүдэр, нийт хуулах хөрсний хэмжээ 479.8мян.м³, хөрс хуулалтын дундаж коэффициент 6.0м³/тн болно.

Тус “Хонгор-1” –ийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар жилдээ 180.0 хүртэл мян.м³ хөрс хуулж, 30.0мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай байхаар тооцоолсон. БОНЕУ-ний дүгнэлтэнд тусгасан гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.



Хүснэгт 13. БОНЕҮ-ний гол шалгуурууд болон сөрөг нөлөө үүсэх нөхцөлүүд

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд
Төслийн байршилтай холбоотой шалгуурууд	
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	<ul style="list-style-type: none"> ➢ Төслийн талбайгаас Их нарт БНГ нь баруун зүгт 22км-ийн зайд байрладаг ➢ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд нийт 13 ширхэг байх ба төслийн талбайгаас 11.3-45.5 км зайд байрладаг ➢ Хамгийн ойр байрлах ОНТХГ нь урд зүгт “Бага нардын хад” 11.3 км –ийн зайд, зүүн урд зүгт “Борнуур” 11.5 км-ийн зайд байрладаг.
Хүний нөлөө болон байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг эсэх	<ul style="list-style-type: none"> ➢ Орон нутагт салхины нөлөө ихтэй ➢ Жилд орох хур тунадас бага учир хуурайшил их ➢ Хээрийн түймрийн аюулын эрсдэл их
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	<ul style="list-style-type: none"> ➢ Төслийн талбай нь сумын хил дагуу байрлана. ➢ Ойрын хугацаанд төлөвлөсөн төлөвлөлт байхгүй
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	<ul style="list-style-type: none"> ➢ Төсөл хэрэгжүүлэх хугацаа богино, ил болон далд аргаар олборлох бөгөөд уурхайг хаасны дараа нөхөн сэргээх шаардлагатай ➢ Төслийн тооцоогоор олборлотын дараагаар 130 м өргөн, 280 м урттай, 55 орчим метр гүн ухаш үүснэ. Мөн урьд онуудад олборлолтонд өртсөн “Хонгор-1” хэсгийн нөхөн сэргээлт хийх талбай нь 527м өргөнтэй, 925м урттай ил уурхайн болон овоолгын талбайнууд байна. ➢ Уурхайн хажуугийн ерөнхий налуу 52 градус, гүн 55м учирMNS5915; 2008 стандартын “Ил уурхайгаар ашиглах явцад эврэх газрын ангилал”-аар дэнжилсэн, дунд зэрэг гүнтэй уурхайд хамаарна. ➢ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн ойр орчимд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд байгаа ба ихэнх нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг болно. Иймд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс хуримтлагдах нөлөөлөл үүсэх магадлал их байна.
Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд	



<p>Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах эсэх • Дуу чимээ доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх эсэх 	<ul style="list-style-type: none"> ➢ Уурхайн тээвэрлэлт жонш бутлах ачих үед үүсэх тоосжилт /тээвэрлэлтээс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл салхины хурд 10м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцорын агууламж 300м зайд 103 мкг/м³ буюу стандарт утгаас 3 мкг/м³ хэмжээгээр илүү байна./ ➢ Тэсэлгээ хийж буй газрын орчимд тэсэлгээ хийсний дараа үүсэх тоосонцор үүлний өндөр түүний хамгийн их утгаа авах үед 175.5 м бөгөөд үүсэх үүлний эзлэхүүн 2,664.0 мян.м³ байна. Тоосонцор үүл 175.5м өндөрт 72 сек хугацаанд үүсэх бөгөөд энэ үед агаар орчинд тархах тоосонцрын хамгийн их агууламж 556.4 мкг/м³ нь эх үүсвэрээс 788.3 м зайд ажиглагдана. Үүнээс цааш 4500м зайд тоосонцорын агууламж 99.1 мкг/м³ буюу MNS 4585;2016 стандартын утгаас 0.8 мкг/м³-аар бага байна. ➢ Шатах тослох материалаас үүдэлтэй агаарын бохирдол $CO=0.1\text{гр} * 76.6 = 7.66 \text{ гр}$ $CH=0.03\text{гр} * 76.6 = 2.298\text{гр}$ $NO_2=0.04\text{гр} * 76.6 = 3.064\text{гр}$ $SO_2=0.02\text{гр} * 76.6 = 1.532\text{гр}$ Хөө тортог=$15.5\text{кг} * 76.6 = 1187.3\text{кг}$ Бензопирин=$0.32 \text{ гр} * 76.6 = 24.512 \text{ гр}$ ➢ Нүүрстөрөгчийн исэл, азотын давхар исэл, нүүрстөрөгч, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, бензпирен, альдегид зэрэг бохирдуулагч бодисуудын агаарт тархах зай нь бодисын шинж чанараас хамаараад 150-200 м байдаг. ➢ Техник тоног төхөөрөмжийн дуу чимээ ➢ Ахуйн хог хаягдал бохирын үнэр <ul style="list-style-type: none"> • Төслийн ашиглалтын хугацаанд 3915 кг хатуу хог хаягдал цугларна. Энэ ялгарсан хатуу хог хаягдалын 30% чийг, 25-30% шатах хэсэг, 30-35% үндсэн хаягдал байна. 10-12% дахин ашиглагдах боломжтой хаягдал ялгарна. • Нийт төсөл хэрэгжих хугацаанд унд ахуйд 1044.0 м³/жил ус хэрэглэнэ гэж үзсэн бөгөөд үүнээс 70% нь шингэн хаягдал болно гэж үзвэл 730.8м³/жил хаягдал ус төслийн хэмжээнд хоногт 4.9 м³ үүсэж байна.
<p>Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> • Усны нөөцөд хомсдол үүсэх эсэх 	<ul style="list-style-type: none"> ➢ Унд ахуйн хэрэглээний усыг гүний худгаас хангана. ➢ Унд ахуйн хэрэглээнд жилд 652.5м³, нийт ашиглалтын 3 жилийн хугацаанд 1957.5м³ усыг зөөврөөр хангана. Унд ахуйн хэрэглээний уснаас



<ul style="list-style-type: none"> • Цэнгэг усны нөөцийг ашиглах эсэх • Ус бохирдуулах эсэх 	<p>хоногт 70 хувь нь ахуйн хэрэглээнээс гарах бохир ус байна.</p>
<p>Газрын хэвлий</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Төслийн үйл ажиллагаагаар 55 метрийн гүн, 280 м урт, 130м өргөн 10.5 га талбайд ил уурхайн ухааш үүсэж, 508.8 мян.м³ уулын хурдас чулуулгийг ухаж газрын хэвлийд эвдрэл үүсгэнэ.
<p>Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> • Хөрс эвдрэх эсэх • Хөрс бохирдох эсэх • Хөрс доройтох цөлжих эсэх 	<ul style="list-style-type: none"> ➢ Төслийн үйл ажиллагаагаар нийт 479.8 мян.тм³ хөрсийг хуулж эвдэх, талхалж доройдуулах ➢ Хөрсний овоолгууд 24.5 га, ил уурхайн ухааш 10.5 га талбай, барилга байгууламж 0.03 га, засварын төв 0.02 га, ШТС 0.01 га , агуулах 0.03 га, шороон зам 0.17 га нийт 35.26 га газрын говийн бор хөрс бүхий байгалийн үржил шимээр хэвийн, чанарын үзүүлэлтээр дунд үнэлгээтэй хөрсөн бүрхэвч шууд хөндөгдөнө. ➢ Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр 35.26 га талбай нь биет хэмжээгээр элэгдэл, эвдрэлд шууд өртөж байгаа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн нийт талбайн /111.97га/ 31.5% байна. ➢ Техник ашиглалт, засвар үйлчилгээ, шатах тослох материалын хэрэглээ, ахуйн хог хаягдал зэргээс хөрсний бохирдол үүсэж болзошгүй
<p>Ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> • Ургамалан нөмрөг ой мод өртөх эсэх • Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх 	<ul style="list-style-type: none"> ➢ Хөрс хуулалт дотоод гадаад тээвэрлэлтээс үүдэлтэй ургамлан нөмрөг биет хэмжээгээр сүйтгэгдэнэ. ➢ Бэлчээрийн ашиглалтад сөргөөр нөлөөлж идэмжит ургамал түрэгдэнэ. ➢ Түр суурьшил, техник парклат бүхий газруудад ургамлан нөмрөг талхлагдана. ➢ Орчны бохирдол, доройтлын улмаас ургамлын ургах орчин хязгаарлагдмал хүрээнд муудна. ➢ Ургамлан нөмрөг багасаж халцгай газрын талбай нэмэгдсэнээр хөрс, салхиар хийсэх, усанд урсах зэргээр газрын эвдрэл, элэгдэл нэмэгдэх ➢ Төслийн үйл ажиллагаанаас 35.26 га газрын баглуур –таана-хялганат, бударгана-хөмүүл-хялгана бүлгэмдэл бүхий ургамлан намраг биет хэлбэрээр шууд нөлөөлөлд өртөж байна. ➢ Дотоод болон гадаад тээвэрлэлтийн зам , тэсэлгээ нь агаар дахь тоосонцорын эх үүсвэр болж, тоосонцор нь буцаад /788м хүртэл зайд/ хөрс, ургамлан бүрхэвчийн шинж чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
<p>Ан, амьтанд үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> • Зэрлэг амьтадын орчныг 	<ul style="list-style-type: none"> ➢ Уурхайн ажил эхэлж өнгөн хөрсийг хуулсанаар тухайн нутагт амьдардаг мэргэчид, мөлхөгчид болон могой гм сээр нуруутан амьтадын амьдрах орчныг



<p>доройтуулах эсэх</p> <ul style="list-style-type: none"> • Ховор болон нэн ховор амьтан өртөх эсэх 	<p>сүйтгэж, эдгээр амьтад нэг бол амьдрах орчноо сэлгэж нүүх эсвэл үхэж хорогдох.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Өнгөн хөрсийг хуулсанаар шавжны амьдрах орчинд нөлөөлж, сээр нуруугүй амьтадын тоог бууруулах магадлалтай. Гэвч уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн экологийн нөхцөл байдал дахь өөрчлөлтийн улмаас зарим зүйлийн тоо толгой өсөн нэмэгдэж болзошгүй ➤ Дуу чимээ, гэрэл тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн ба машин техникийн ажил эхэлж олборлох ажиллагаа эхлэхээр зэрлэг амьтад уурхайн талбайн ойр орчимоос дайжих ➤ Биологийн төрөл зүйлийн нэгийг нөгөөгөөр орлуулж болдоггүй. Бие биеийнхээ хэвийн амьдралаас шууд шалтгаалан экологийн тэнцэлд зохицон байдаг гинжин хэлхээ тасрахаар экологийн тэнцэл алдагдаж тэнд амьдралгүй болдог зүй тогтол үүсэх ➤ Уурхайн ухааш нүх, суваг, шуудуунд мал, амьтан унах ялангуяа салхи шуурганд уруудсан мал уурхайн ухашианд олноороо унаж үхэж үрэгдэх ➤ Шинээр ирж ажиллаж суурьших хүмүүс зэрлэг амьтадыг хууль бусаар агнаж болзошгүй
<p>Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд</p>	
<p>Орон нутгийн оршин суугчдад үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> • Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх эсэх • Оршин суугчидын нийгмийн байдал сөрөг нөлөөтэй эсэх • Нөлөөлөд өртөж болзошгүй төв суурин газар байгаа эсэх • Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх 	<ul style="list-style-type: none"> ➤ Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд айл, малын суурьшил бага тул газар ашиглалтанд сөрөг нөлөө бага ➤ Дорноговь аймгийн Айраг сумын төвөөс 26 км зайд, Даланжаргалан сумаас 13 км зайд төслийн талбай нь байршина. ➤ Төслийн нөлөөллийн бүсэд суурьшил байхгүй тул нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэхгүй. ➤ Ашигт малтмалын газрын тосны газраас mv-005692 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Мин Ли Да” ХХК-д 2018.11.07-ноос 2033.04.28 өдрийг дуустал хугацаагаар олгосон болно.
<p>Нийгэм эдийн засгийн үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно. ➤ Нийт төслийн хугацаанд 20 хүн ажлын байраар хангагдана. ➤ 1 ажилтны дундаж цалин 1290.0 мянган төгрөг байна.



	<ul style="list-style-type: none"> ➤ Ханган нийлүүлэх эрэлт/хүнсний хангамж, ажлын хувцас ахуйн хангамж, түлш шатахуун сэлбэг хэрэгсэл зэргийн хэрэгцээ үүсэх тул орон нутагт хувиарилах боломжтой. ➤ Улс орон нутгийн төсөвт ашиглалтын хугацаанд нийт 496.97 сая.төг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 211.004 сая.төг, ус ашигласны төлбөрт 0.13 сая.төгрөгийг төвлөрүүлхээр байна.
<p>Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> • Сөрөг нөлөөлөлд өртөх түүх ,соёлын үнэт зүйл бий эсэх 	<ul style="list-style-type: none"> ➤ Уурхайн нөлөөллийн бүсэд түүх соёлын үнэт зүйл байгаа эсэхийг тодруулахаар 2019 онд ШУТИС,БХС,ХҮМҮҮНЛЭГИЙН САЛБАР –р Археологи болон Палеонтологийн авран хамгаалах хайгуул, малтлага, тандалт судалгаа хийлгэсэн. • Палеонтологийн тандан судалгааны дүнд эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэр илрээгүй болно. • Археологийн судалгааны үр дүнд эзэмшил бүхий талбайд 4 ширхэг, талбайн гадна 26 ширхэг нийт 30 тооны эртний хүрлийн үед холбогдох чулуун дараас бүхий булш оршуулгын төрлийн дурсгал илэрсэн.
<p>Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> • Нутгийн иргэд оршин суугчидад сөргөөр нөлөөлөх эсэх • Төслийн бүхий л шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх эсэх 	<ul style="list-style-type: none"> ➤ Уурхайн тэсэлгээний ажлын үед хөдөлмөрийн аюулгүй байлыг хангаагүйгээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл ➤ Үйлдвэр технологийн үйл ажиллагаанд хортой болон аюултай бодис, тэсрэх бодисыг зөв зохистой хэрэглээгүйгээс хүний эрүүл мэнд хохирох эрсдэлтэй. ➤ Төслийн хэрэгжилтийн хүрээнд дагаж мөрдөх хөдөлмөр хамгааллын харилцааг төслийн ТЭЗҮ-д тусгайлан заасан байна.

2.2.Байгаль орчин нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл

2.2.1. Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн цар хүрээ

Хонгорын хайлуур жоншны орд нь манай орны зүүн захын төл хээрийн бүс өвөлдөө салхи ихтэй, зундаа хур бороо бага хуурай халуун уур амьсгалтай учир хээрийн түймэр гарах эрсдэл өндөр юм. Төслийн талбан орчимд суурьшилын бүс байхгүй нөлөөлөл хуримтлагдгах нөхцөлгүй юм. Уурхайн ашиглалтын хугацаа бага учир нөхөн сэргээлийн ажил хийгдэнэ. 2019 онд төслийн эхний жил учир нөхөн сэргээлт хийхгүй гэж төлөвлөсөн хэдийч 0,5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж Айраг сумыг ЗДТГ-т хүлээлгэн өгч акт үйлдсэн.



Төслийн талбайн хамгийн ойр байрлах орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь урд зүгт бага нардын хад 11.3 км-н зайд, зүүн урд зүгт Борнуур 11.5 км-н зайд тус тус байрлана.

Хүснэгт 14. Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн үзүүлэлт

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр			Нөлөөллийн үнэлгээ		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Бага буюу нөлөөгүй	Дунд	Эрчимтэй
Их нартын байгалийн нөөц газар нь төслийн талбайгаас 22 км зайд баруун зүгт байрлана.			+	+		
Хадан хошуу ОНТХГ нь төслийн талбайгаас 45.5 км зайд зүүн зүгт байрлана.			+	+		
Улаан зээг ОНТХГ нь төслийн талбайгаас 28 км зайд зүүн зүгт байрлана.			+	+		
Үнэгдийн хошуу ОНТХГ нь төслийн талбайгаас 38.3 км зайд зүүн зүгт байрлана.			+	+		
Цагаан хад ОНТХГ нь төслийн талбайгаас 11.5 км зайд зүүн зүгт байрлана.		+			+	
Цагаан дэлийн агуй дотор ОНТХГ нь төслийн талбайгаас 17.5 км зайд урд зүгт байрлана.			+	+		
Онгон халзан ОНТХГ нь төслийн талбайгаас 26.8 км зайд зүүн зүгт байрлана.			+	+		
Нүдэнгийн хонхор дотор ОНТХГ нь төслийн талбайгаас 44.0 км зайд урд зүгт байрлана.			+	+		
Дай уул ОНТХГ нь төслийн талбайгаас 46 км зайд баруун хойд зүгт байрлана.			+	+		
Баян уул ОНТХГ нь төслийн талбайгаас 26.5 км зайд урд зүгт байрлана.			+	+		
Бага цардын хад ОНТХГ нь төслийн талбайгаас 11.3 км зайд урд зүгт байрлана.		+			+	
Төсөл хэрэгжих нутгийн эмзэг байдалд үзүүлэх нөлөө						
Орон нутгийн салхи тогтворгүйгээс үүсэх нөлөө			+	+		
Жилд орох хур тунадас бага хээрийн түймэр гарах эрсдэл их		+			+	
Газар ашиглалтын байдалд үзүүлэх нөлөө						
Бүтээн байгуулалт төлөвлөсөн газар байхгүй			+	+		
Бэлчээр ашиглалтад үзүүлэх нөлөө	+				+	
Нөлөөллийн хуримтлагдах байдал						
Төслийн үргэлжлэх хугацаа урт	+				+	
Нөхөн сэргээгдэх хугацаа удаашралтай	+				+	
Дүн	3	3	11	10	7	0



2.2.2. Эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөө

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш” –г ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаагаар нийт 35.26 га талбай эвдрэлд өртөхөөр байна. Үүнд хөрсний овоолгууд 24.5 га, ил уурхайн ухаш 10.5 га талбай, барилга байгууламж 0.03 га, засварын төв 0.02 га, ШТС 0.01 га , агуулах 0.03 га, шороон зам 0.17 га байна. Нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 31.5% нь шууд эвдрэлд өртөж байна.

Хүснэгт 15. Уурхайн дэд бүтэц

№	Уурхайн дэд бүтэц	Га
1	Хөрсний овоолгууд	24.5
2	Ил уурхайн ухаш	10.5
3	Барилга байгууламж	0.03
4	Засварын төв	0.02
5	ШТС	0.01
6	Агуулах	0.03
7	Олон салаа шороон зам	0.17
Нийт		35.26

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн ойр орчимд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай 4, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай 13 ширхэг байгаа ба ихэнх нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг болно. Иймд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс хуримтлагдах нөлөөлөл үүсэх магадлал их байна.

Хүснэгт 16. Эдэлбэр газарт үзүүлэх нөлөөллийн эрчим

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Газрын нэгдсэн санд үзүүлэх нөлөө			+	
Бусдын газар ашиглах, эзэмших эрхэд үзүүлэх нөлөө	+			
Бэлчээрийн ашиглалтанд үзүүлэх нөлөө			+	
Газар ашиглах цаашдын төлөвлөлт, хөгжлийн хөтөлбөрт үзүүлэх нөлөө		+		
Дүгнэлт	Төслийн үйл ажиллагаанаас эдэлбэр газарт ерөнхийдөө бага зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Тоон үзүүлэлтээр авч үзвэл төслөөс эдэлбэр газарт нөлөө үзүүлж болзошгүй 4 үзүүлэлтээс 50% нь дунд, 25% нь бага, 25% нь нөлөөгүй байгаа ба эндээс үзвэл эдэлбэр газарт үзүүлэх нөлөөлөл дунд зэрэг байна.			

2.2.3. Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө

Хонгорын уурхайн үйл ажиллагааны явцад агаар мандалд хаях бохирдуулагч эх үүсвэрүүдэд цэгэн болон талбайн, түр зуурын эх үүсвэрүүд багтана. агаарт бохирдуулагч эх үүсвэрүүдийг дараах байдлаар хуваан үзэж болно.



Үүнд:

- Жонш олборлох цэгэн эх үүсвэр
- Материал дамжуулах, тээвэрлэх хэсгүүд дэх бохирдолын цэгэн эх үүсвэрүүд
- Тээврийн хэрэгсэлээс ялгарах бохирдуулагчид
- Ил талбай, зам овоолгууд
- Хог хаягдалын үнэр зэрэг болно.

Агаар бохирдуулах бодисыг хүний организмд үзүүлэх нөлөөллөөр нь физикийн ба химийн гэж ангилна. Физик нөхцөлд: ионжуулах цацрагийн эх үүсвэр болох цацраг ивэвхт элементүүд, дулааны бохирдол, шуугиан ба нам давтамжийн чичиргээ, химийнхэнд: хийн төлөв байдалтай нүүрстөрөгчийн нэгдэлүүд ба шингэн нүүрстөрөгчид, угаагч бодис, пластмасс, пестицид ба бусад нийлэг бодисууд, хүхрийн нэгдлүүд, азотын нэгдэлүүд, хүнд металлууд, фторын нэгдэлүүд, хатуу хольцууд, органик нэгдэлүүд зэрэг болно. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл үзүүлэх дараах эх үүсвэрүүд байна.

Хүснэгт 17. Агаарт үзүүлэх нөлөөллийн эрчим

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Шаталтад хөдөлгүүрээс ялгарах утаа тортгоос үүсэх бохирдолын нөлөө			+	
Уурхайн үйл ажиллагааны үед бий болох тоосжилт нь уурхайн талбай, түүний ойр орчимын нутаг дэвсгэрийн агаарын чанарыг муутгах			+	
Үүссэн тоосжилтын хэмжээ нь талбай дах ажлын нөхцөлийг муутгах, улмаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх			+	
Тэсэлгээний үед үүссэн тоосоор орчны хөрс бохирдох				+
Уурхайн болон тээвэрлэх, шороо ачих буулгах үйл ажиллагаанаас үүссэн тоосны бохирдолын нөлөө			+	
Ахуйн хог хаягдал, бохир ус, нийтийн жорлонгийн ашиглалтаас үүсэх орчны бохирдолын нөлөө		+		
Салхи цаг уурын хүчин зүйлээс шалтгаалан агаарын бохирдолын орон зай, цар хүрээнд үзүүлэх нөлөө		+		
Дүгнэлт	Төслийн үйл ажиллагаанаас агаарт үзүүлэх сөрөг нөлөөг 7 үзүүлэлтээр авч үзэхэд 28.6% нь бага нөлөөлөлтэй, 57.1% нь дунд нөлөөлөлтэй, 14.2% нь их нөлөөлөлтэй байна. агаарын чанар төслийн үйл ажиллагаа дууссанаар сөрөг нөлөө арилж хуримтлагдахгүй болохыг харуулна.			



2.2.4. Газрын хэвлийд үзүүлэх нөлөө

Төслийн үйл ажиллагаагаар 55 метрийн гүн, 280 м урт, 130м өргөн 10.5 га талбайд ил уурхайн ухааш үүсэж, 508.8 мян.м³ уулын хурдас чулуулгийг ухааж газрын хэвлийд эвдрэл үүсгэнэ. Мөн урьд онуудад олборлолтонд өртсөн “Хонгор-2” хэсгийн нөхөн сэргээлт хийх талбай нь 527м өргөнтэй, 925м урттай ил уурхайн ухааш үүссэн байна.

Төсөл хэрэгжээд дууссаны дараа хэвлийд үүссэн орон зайд дүүргэлт хийж нөхөн сэргээхэд шимт хөрсөөр хучилт хийх тул газрын давхаргын дээд хэсэгт хадгалагдах боломжтой бөгөөд нөхөн сэргээгдсэн хэвлийн бүтэц, тогтоц цаашид цаг хугацааны хувьд нөхөн сэргээгдэх тул төслөөс үүсэх сөрөг нөлөөлөл үлдэж хуримтлагдахгүй.

Хүснэгт 18. Газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийн эрчим

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Шимт хөрсний үе давхаргад үзүүлэх нөлөө			+	
Үндсэн хөрсний давхаргад үзүүлэх нөлөө			+	
Хурдас чулуулагт үзүүлэх нөлөө				+
Газрын доорх уст давхаргад үзүүлэх нөлөө			+	
Газрын хэвлийн ашигласан орон зайн бүтэц, тогтоц үзүүлэх нөлөө				+
Дүгнэлт	Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөг 5 үзүүлэлтээр авч үзэхэд 60% нь дунд зэргийн нөлөөтэй, 40% нь их зэргийн нөлөөтэй байгаагаас үзвэл төслөөс газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөө дундаас их түвшинд үнэлэгдэж байна.			

2.2.5. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөө

Төслийн технологийн хэрэглээнд ус ашиглахгүй харин унд, ахуйн болон зам талбайн усалгаанд шаардлагатай усыг зөөврөөр хангана. Унд ахуйн хэрэглээний усны 70 хувь нь шингэн хаягдал болно.

Тухайн нутагт тогтмол урсгалтай гол горхи байдаггүй, харин цас хайлах үеэр юмуу хүчтэй үргэлжилсэн борооны үед түр эжжрын урсгалтай горхи хөндий, амуудад даган урсдаг ба олон тооны жижиг нуурууд үүсдэг боловч тэдгээр нь хурдан зуур тогтоод ширгэдэг. Төслийн талбайн орчим 8-15 км-н зайд зун хур борооны усаар тэжээгддэг нэр тодорхойгүй хэд хэдэн нуурууд байдаг. Айраг болон Даланжаргалан суманд гүний худаг байдаг ба усны чанар сайн ундарга сайтай тул ахуйн хэрэгцээний усны эх үүсвэр болдог.



Хүснэгт 19. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн эрчим

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Гадаргын усны урсац, голдрилд үзүүлэх нөлөө	+			
Гадаргын ус бохирдуулах нөлөө	+			
Газрын доорх усны нөөцөд үзүүлэх нөлөө		+		
Газрын доорх ус бохирдуулах нөлөө		+		
Дүгнэлт	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөг 4 үзүүлэлтээр авч үзвэл 50% нь бага зэргийн, 50% нь нөлөөгүй байна.			

2.2.6. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн заримдаг цөлийн бор хөрсний дэд бүс Алтан ширээн тойрогт хамаарагдана. (ШУА, Газарзүйн хүрээлэн 2009). Төслийн талбайд бүхэлдээ говийн бор хөрс тархасан байна. Төслийн хэрэгцээнд 24.5 га хөрсний овоолго, 10.5 га ил уурхайн ухаш, барилга байгууламж 0.03 га, засварын төв 0.02 га, ШТС 0.01 га, агуулах 0.03 га, шороон зам 0.17 га нийт 35.26 га талбайг хамарсан хөрс биет хэмжээгээр эвдэгдэж байна.

Хүснэгт 20. Хөрсөнд үзүүлэх нөлөөллийн эрчимийн зэрэглэл

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Уурхайн олборлотын үйл ажиллагаанаас 10.5 га талбай бүхий 55 метр гүнтэй 508.8 мян.м ³ уулын чулуулгийг ухаж газрын гүнд хоосон орон зай үүснэ.				+
Уурхайн ажилчидын байр болон төслийн барилга байгууламжийн орчмын ройнд цахилгаан дамжуулах шугамын татах шон суулгах зэргээр хөрсөн бүрхэвч эвдрэлд орж доройтсон.			+	
Жонш олборлох явцад уурхайн карьер овоолго зэрэг ашиглалтын талбайд үүсэх уурхайлалтаар нийт 35.26 орчим га талбай хөрсөн бүрхэвчгүй болж эвдэрч доройтсон байна.				+
Ил уурхайн ухаш гадаад овоолгын нийт 24.5 га талбайд хадгалсан хөрсний ялзмаг удаан хугацаагаар хадгалсанаас шимт чанараа алдана.			+	
Уурхайн дотоод тээврийн замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдсанаас нарийн ширхэгтэй тоос агаарт дэгдэж тэр хэмжээгээр орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтолд оруулна.			+	
Газар доох усны шүүлтүүрээс ойр орчимын хөрсөн бүрхэвч чийгийн дутагдалд орж хуурайшилт үүснэ.			+	
Дүгнэлт	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөг 6 үзүүлэлтээр авч үзэхэд 60% нь дунд нөлөөлөлтэй, 40 % нь их эрчимтэй зэрэглэлтэй байна, 14.2% нь их нөлөөлөлтэй байна. хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөө нь үр шимгүй болтлоо сүйтгэгдэх, бохирдох зэрэг сүйрлийн түвшний сөрөг нөлөө үгүй байна.			



Цаашид ашиглалтын талбай нэмэгдэхийн хирээр хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөө цар хүрээний хувьд тэлж өргөгсөх боловч эрчимийн хувьд эвдэрлийн зэрэглэл нэмэгдэхгүй байх боломжтой юм.

2.2.7. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө

“Хонгорын хайлуур жоншны орд” төслийн хүрээнд жонш олборлох үйл ажиллагаанаас 35.26 га талбайн ургамлан нөмрөг шууд устах, жонш буулгах үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг дарагдах, тоосжилтонд өртөх зэрэг гол сөрөг нөлөөллүүд үзүүлнэ. Энэ бүлэгт “Хонгорын хайлуур жоншны орд” төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх дээрх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн эрчимийн үнэлгээг харуулав.

Төслийн талбай, түүний орчмын газар нутаг нь Монгол орны ургамал Газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна.

1. Төслийн үйл ажиллагаанаас 24.5 га хөрсний овоолго, ил уурхайн ухаш 10.5 га талбай, барилга байгууламж 0.03 га, засварын төв 0.02 га, ШТС 0.01 га, агуулах 0.03 га, шороон зам 0.17 га нийт 35.26 га талбайн ургамлан нөмрөг биет хэмжээгээр шууд устана. Уурхайлалт болон бусад дагалдах үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг устаж, доройтох эрсдэлтэй ба цаашид ургамлын бүлгэмдэлд урт хугацааны нөлөөллийг бий болгоно.
2. Хөрс хуулалт жонш болон хөрс ачих буулгах, мөн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах. Энэ нь чийгийн дутагдалтай, хур тунадасны хэмжээнээс ууршилт давамгайлах бүс нутаг учир ил уурайн үйл ажиллагаа, тээврийн хөдөлгөөн, ачилт, буулгалт, хөрс хуулалт зэргээс үүдэж их хэмжээний тоос агаарт дэгдэн улмаар газрын гадаргад бууж орчны тоосжилтыг үүсгэнэ.
3. Мөн Айраг суманд нийт салхины чиглэлийн 42% нь хойд зүгээс, 19% нь баруун хойд зүгээс, 8 % нь баруун зүгээс давтагдалтай байдаг. Мөн салхины их хурд ихэнх саруудад 15м/с-с их, хаврын саруудад 28м/с хүрч байжээ. Байнгын тоосжилтын нөлөөгөөр ургамлын ургалтын хугацаанд тухайн орчны ургамлын зүйлүүдийн амсарын эс бөглөрч, физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдан, фотосинтезийн эрчим буурч, ургамлын биомассын хэмжээ буурч, аажмаар үхэхэд хүргэж болзошгүй.
4. Төслийн үйл ажиллагаагаар нийт 35.26 га талбай бүхий баглуур-таана--хялганат, бударгана-хөмүүл-хялганат ургамлан бүлгэмдэл шууд нөлөөлөлд өртөх ба энэ нь бэлчээрийн хэмжээг тодорхой хэмжээний ургацаар бууруулж байна.



Хүснэгт 21. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчим, үнэлгээ

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Уулын ажлын техник ажиллагаа, хөрс хуулалтаар ургамал биет хэмжээгээр сүйтгэгдлэх				+
Хуулж авсан шимт хөрсийг удаан хадгалсанаас ургамал ургах орчин доройтох, амьдрах чадвараа алдах			+	
Уулын ажлын үед тээвэрлэлт, түр зам ашиглалт, орчны газар ашиглалтын дарамт, тоосжилтоос ургах орчин доройтох			+	
Ажилчидын түр байршил, кемп ашиглалт, техник парклат зэрэг газрын орчимд ургамлан нөмрөг талхлагдана.		+		
Бэлчээрийн ургамлын төрөл зүйл ядуурч , багасахад үзүүлэх нөлөө		+		
Дүгнэлт	Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөг 5 үзүүлэлтээр авч үзэхэд 40% нь бага нөлөөлөлтэй, 40 % нь дунд, 20% нь их эрчимтэй зэрэглэлтэй байна. ургамалд үзүүлэх сөрөг нөлөө нь тодорхой зүйл ургамал устаж үгүй болох хүртэл сүйрлийн түвшний сөрөг нөлөө үзүүлэхгүй. Тиймээс ургамлан нөмрөгийг нөхөн сэргээж, зориулалтын аргаар ургамалжуулах шаардлагатай бөгөөд энэ нь аяндаа цэгцрэх үйл явцыг ихээхэн хэмжээгээр хурдасгана.			

2.2.8. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөө

Тухайн нутаг нь цөлөрхөг хээрийн бүс, амьтдын тархалт сийрэг, байршилт нь цөөвтөр орчинд төвлөрсөн, алаг цоог байдалтай тархана. Энэ орчинд амьтдын зүйлийн бүрдэл нэн цөөн, харин цөлөрхөг хээрийн өвөрмөц экосистем бүхий уул хад, хайлаас зэгс бүхий байгалийн задгай устай нуур, тогтоол устай газруудад цөлөрхөг хээрийн үндсэн амьтад орогнон байрших, нүүдлийн амьтад уст газраар дайран өнгөрөх нөхцөлтэй.

Хүснэгт 22. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн эрчим, үнэлгээ

Нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэглэл			
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх			+	
Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг Борнуур болон Бага нардын ам зэрэгт нутгийн ан амьтадын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх			+	
Хээрийн мэрэгч амьтадын амьдрах орчин, нутагшил, байршил, үржилд үзүүлэх нөлөө		+		
Хээрийн бүсийн, байнгын нутагшилтай шувуудад үзүүлэх нөлөө		+		



Уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор байршил бий болох үүнийг дагаад уурхайн ажиллагсад болон шинээр шилжин ирэгсэд ан амьтадыг хулгайгаар агнаж болзошгүй		+		
Орон нутгийн идээшилтэй бэлчээрийн хөхтөн амьтадад амьдрах орчин, үржилд үзүүлэх нөлөө		+		
Дүгнэлт	Төслийн үйл ажиллагаанаас амьтадад үзүүлэх сөрөг нөлөөг 6 үзүүлэлтээр авч үзэхэд 33.4% нь бага нөлөөлөлтэй, 66.6 % нь дунд үзүүлэлттэй байна. Амьтадад үзүүлэх сөрөг нөлөө нь амьтадын амьдрах орчинд ноцтой сүйрлийн түвшинд хүртэл нөлөөлөхгүй.			

2.2.9. Түүх, соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөө

Уурхайн нөлөөллийн бүсэд түүх соёлын үнэт зүйл байгаа эсэхийг тодруулахаар ШУТИС,БХС,ХҮМҮҮНЛЭГИЙН САЛБАР –р Археологи болон Палеонтологийн авран хамгаалах хайгуул, малтлага, тандалт судалгаа хийлгэсэн.

- Палеонтологийн тандан судалгааны дүнд эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэр илрээгүй болно.
- Археологийн судалгааны үр дүнд эзэмшил бүхий талбайд 4 ширхэг, талбайн гадна 26 ширхэг нийт 30 тооны эртний хүрлийн үед холбогдох чулуун дараас бүхий булш оршуулгын төрлийн дурсгал илэрсэн.

Цаашид төсөлийн үйл ажиллагааны үед палеонтологийн олдвор илэрвэл төрийн холбогдох байгууллагад заавал мэдэгдэнэ.

2.2.10. Тусгай хамгаалатын газар нутагт үзүүлэх сөрөг нөлөө

Айраг сумын хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нийт 17 ширхэг байна. Тухайлбал Хадан хошуу ОНТХГ нь төслийн талбайгаас 45.5 км зайд зүүн зүгт, Улаан зээг ОНТХГ нь төслийн талбайгаас 28 км зайд зүүн зүгт, Үнэгдийн хошуу ОНТХГ нь төслийн талбайгаас 38.3 км зайд зүүн зүгт, Цагаан хад ОНТХГ нь төслийн талбайгаас 11.5 км зайд зүүн зүгт, Цагаан дэлийн агуй дотор ОНТХГ нь төслийн талбайгаас 17.5 км зайд урд зүгт, Онгон халзан ОНТХГ нь төслийн талбайгаас 26.8 км зайд зүүн зүгт, Нүдэнгийн хонхор дотор ОНТХГ нь төслийн талбайгаас 44.0 км зайд урд зүгт, Дай уул ОНТХГ нь төслийн талбайгаас 46 км зайд баруун хойд зүгт, Баян уул ОНТХГ нь төслийн талбайгаас 26.5 км зайд урд зүгт, Бага цардын хад ОНТХГ нь төслийн талбайгаас 11.3 км зайд урд зүгт тус тус байрлана. Төслийн талбайн хамгийн ойр байрлах Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь Бага цардын хад хэмээх тусгай хамгаалалттай газар нутаг байна.

2.2.11. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ

БОНЕУ-ний дүгнэлт болон БОТБҮ-ний тайланд заасан нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээний гол шалгууруудыг тухайлан авч үзвэл төслийн үйл ажиллагааны үр дүнд үзүүлэх сөрөг нөлөөгүй байна. төслийн талбай орчмын оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим маш бага, бараг нөлөөгүй түвшинд байх бол орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө нь төлөвийн хувьд эерэг, эрчимийн хувьд дунд зэрэг



байна гэж “Хонгорын хайлуур жоншны орд”-д БОНЕҮ-г хийсэн “Ашид-Ананда” ХХК-н тайланд тусгасан.

Хүснэгт 23. Төслөөс орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө

Нөлөөлөл	Нөлөөллийн төлөв		Нөлөөллийн эрчим		
	Эерэг	Сөрөг	нөлөөгүй	Дунд	эрчимтэй
Оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөө					
Төсөл хэрэгжих талбайн ойр очимд айл малын суурьшил үгүй	+		+		
Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй	+		+		
Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө					
Жонш олборлох үйл ажиллагаа нь ил аргаар олборлож, бутлах технологиор явагдана.		+	+		
Технологийн үйл ажиллагаанд химийн хортой бодис болон аюултай бодис хэрэглэхгүй	+		+		
Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм журмыг тогтоох	+		+		
Орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө					
Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно.	+			+	
Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ.	+			+	
Орон нутгийн төсөвт НӨАТ, ХАОАТ, газар, ус, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хураамж зэрэг орлого орно.	+			+	

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл бага эрчимтэй, дунд түвшинээс хэтрэхгүй байгаа нь төслийн үргэлжлэх хугацаа богино, хөрөнгийн эргэлт багатай холбоотой байна.

2.3. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл

“Мин Ли Да” ХХК –ийн Хонгорын хайлуур жоншны ордыг олборлох төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 37 үзүүлэлтээр нөлөөллийн эрчимийг тодорхойлсоноос эдэлбэр газар, гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл тус бүр 11%, газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл 13%, агаарын чанарт үзүүлэх нөлөө 19%, хөрсөн бүрхэвчид, амьтадын аймагт үзүүлэх нөлөө тус бүр 16%, ургамлан нөмрөг үзүүлэх нөлөө 14% байна.



Төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн 5% нь тодорхой нөлөөгүй байхад, 33% нь бага, 38 % нь дунд, 24% нь их эрчимтэй байгаа ба агаарын чанар, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

Хүснэгт 24. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Сөрөг нөлөөллийн эрчимийн хэсэг					Үнэлгээ		
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	сүйрлийн	Тоо	Хувь	
1	Эдэлбэр газарт үзүүлэх нөлөө		2		2		4	11	
2	Газрын хэвлийд үзүүлэх нөлөө			2	3		5	13	
3	Агаарын чанарт үзүүлэх нөлөө		2	4	1		7	19	
4	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө	2	2				4	11	
5	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөө			4	2		6	16	
6	Ургамал, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө		2	2	1		5	14	
7	Амьтны аймагт үзүүлэх нөлөө		4	2			6	16	
Нөлөөллийн эрчимийн нийт үнэлгээ		37	2	12	14	9	0	37	100
		100	5	33	38	24	0		

Төслийг хэрэгжүүлсэнээр байгаль орчинд сүйрлийн хэмжээнд хүртэл сөрөг нөлөө үзүүлэхгүй байгаа нь олборлотын дууссаны дараа бүрэн нөхөн сэргээснээр байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах боломжтой байгаа юм.

Сөрөг нөлөөллийн эрчимийн үнэлгээгээр сөрөг нөлөөллийн илэрц төслийн технологийн тодорхой үе шатуудад ямар ээлж дараатай байх нь тодорхой харагдахгүй тул Леопольдын матрицаар үнэлсэн байна. Леопольдын матрицын арга нь мэргэжлийн экспертүүдийн өгсөн үнэлэлт, дүнэлтийг үндэслэн технологийн үе шат бүрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болох сөрөг нөлөөллийг үнэлэх онцлогтой. Энд нөлөөллийн харилцан үйлчлэлийг макро ба микро орчинд нь 2 хэмжээст матрицаар илэрхийлж, болзошгүй нөлөөллийн эрчимийг үнэлгээнд авч үзэх чадал байдалтай хослуулан үнэлнэ. Матриц дахь тоон утгын хүртвэрт нөлөөллийн эрчимийг, хуваарьт тухайн нөлөөллийг үнэлж үзэх чухал байдлыг тодорхойлно.

Жонш олборлох урт хугацааны технологийн тодорхой 13 үе шатанд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үндэслэн Леопольдын матрицаар үзвэл агаарын чанар, газрын доорх ус, хөрс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бусад бүрдэл хэсгүүдээс их эрчимтэй байгаа юм. Технологийн үе шатуудаас шимт хөрс хуулах, үндсэн хөрс хуулах тэсэлгээ, ус шүүрүүлэлт зэрэг үйл ажиллагаа хамгийн их эрчимтэй уурхайн тээвэрлэлт, ачиж буулгах үйл ажиллагаа харьцангуй бага эрчимтэй байгаа юм.



Хүснэгт 25. Технологийн тодорхой үе шатуудад үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Технологийн үе шат	Нөлөөлөлд өртөгчид							Дүн
		Эдэлбэр газар	Газрын хэвлий	Агаар	Газрын доорх ус	Хөрс	Ургамал	Амьтан	
1	Кемп байгуулах, тоног төхөөрөмж угсрах	3/3	-	1/1	1/1	3/3	3/3	3/4	14/15
2	Үржил шимт хөрс хуулах	4/6	-	6/8	-	5/8	5/8	4/4	24/34
3	Үндсэн хөрс хуулах	-	6/9	5/9	-	6/8	2/5	-	19/31
4	Хурдас чулуулгын овоолго үүсгэх	3/4	-	2/2	3/5	4/6	3/5	-	15/22
5	Ус шүүрүүлэх, шавхан зайлуулах	-	4/5	-	8/10	-	4/6	-	16/21
6	Уурхайн хөрс сийрэгжүүлэх, тэсэлгээ хийх	-	6/8	-	6/8	-	2/3	3/5	17/24
7	Жонш олборлох, ачих буулгах	-	2/3	2/2	-	1/1	-	-	5/6
8	Дотоод тээвэр	-	-	3/3	3/4	3/3	3/3	-	12/13
9	Гадаад тээвэр	-	-	1/1	3/3	-	-	4/6	8/10
10	Техник засвар үйлчилгээ	-	-	2/2	1/1	4/4	2/2	-	9/9
11	Кемп ашиглалт	-	-	1/1	1/5	3/4	3/4	-	8/14
12	Кемп болон тоног төхөөрөмж буулгах ачих	-	-	1/1	1/1	3/3	3/3	-	8/8
Нийт		7/9	18/22	24/30	27/38	32/40	30/42	14/19	152/162

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгээс эдэлбэр газар, газрын хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө төслийн үе шатуудаар үнэлсэн үнэлгээнд мөн үнэмлэхүй байр суурийг эзэлж, эрчим болон үнэлэмж ихтэйгээр үнэлэгдсэн нь нөлөөллийн эрчимийг үнэлсэн дээрх үнэлгээтэй тохирч байна.

Тиймээс сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах арга хэмжээг хэрэгжүүлсэнээр уурхайг хаасны дараа сөрөг нөлөө хуримтлагдахгүй байх боломжтой ба энэ нь уурхайг хаасны дараах нөхөн сэргээлийн арга хэмжээгээр хэрэгжинэ.



3.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, ГОЛ ЗОРИЛТ, НИЙТ ТӨСӨВ

“Хонгорын хайлуур жонш”-ийг ил болон далд аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардалыг бодитойгоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ын үндсэн зорилтыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

1. БОМТ-нд тусгагдсан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчидын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлсэнээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтанд бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

Хамрах хүрээ:

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

1. Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох
2. Нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох
3. Осол эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох, түүний зардалыг тодорхойлох
4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тодорхойлох
5. Удирдлага зохион байгуулалт олон нийтэд тайлагнах бодлого хөтөлбөрийг боловсруулж холбогдох зардалыг тооцох

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарчим

Төслийн үйл ажиллагаагаа журамлах үүднээс байгууллагын дотоод журам, дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол улсад мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байхаар боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөнө.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үндсэн бичиг баримт нь менежментийн төлөвлөгөө болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүйгээс байгаль орчинд учирсан нөхөн төлбөрийг төсөл хэрэгжүүлэгч хуулийн хүрээнд хүлээнэ.



Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, төсөв

Энэхүү төлөвлөгөө нь 2023 онд бүрэн хэрэгжих бөгөөд төслийн эхний жилд төсөл хэрэгжүүлэгч хүрээлэн буй орчныг бохирдуулахаас сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангахад голлон анхаарч ажилласан бол төслийн хоёр, гурав дахь жил COVID-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулаагүй учир 2023 онд нөхөн сэргээлийн ажил хийгдэж сөрөг нөлөөллийн үзүүлэлтийг байвал зохих норм, стандартын дагуу мөрдөж ажиллахаар төлөвлөсөн.

Төслийг хаасны дараа нөхөн сэргээлтийн чанар, үр дүнд хяналт тавьж, мониторинг хийнэ. Шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийж нэмэлтээр ургамалжуулах бөгөөд цаашид нөхөн сэргээлтийн үр дүнг орон нутагт хүлээлгэн өгнө.

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-нд заагдсан дараах 10 төлөвлөлтийн дагуу нийт /гучин сая гурван зуун хорин дөрвөн/ мянган төгрөг /30.324.000/ төлөвлөсөн байна.

БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	11.000.000
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	4.500.000
3	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний зардал	3.350.000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1.224.000
5	Нөхөн сэргээлтийн зардал	3.500.000
6	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	900.000
7	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох зардал	-
8	Түүх,соёлын өвийг хамгаалах арга хэмжээний зардал	400.000
9	Удирдлага зохион байгуулалтын зардал	3.000.000
10	Оролцогч сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх зардал	2.450,000
Төлөвлөгөөний нийт зардал		30.324.000



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Тоосжилт бууруулах, технологийн замын усалгаа хийх	Шаардлагатай бүх зам	Тн/км	-	-	Үйл ажиллагааны зардал	2,3-р улиралд	“Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 45:2016, “Агаарын тухай хууль”
		Тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээг байршуулна.	Дотоод болон гадаад тээврийн зам	км	-	500.000	500.000	БОМ	
		Хүчтэй салхитай үед уурхайн уулын ажлыг хязгаарлах Хөрс хуулалт, олборлолт, тээвэрлэлт,	Салхины хурд 16м/с –с давсан үед	м/с	-	-	Үйл ажиллагааны зардал	Дулааны улиралд	
	Ус ашиглах хууль эрх зүйн бичиг баримт бүрдүүлэх	Холбогдох байгууллагууд	Тоо/ш	1	500.000	500.000	БОМ		



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Унд ахуйн усанд ус шүүх төхөөрөмж суурилуулах	Уурхайн кемпэд	ш	1	-	Үйл ажиллагааны зардал	БОМ	Усны тухай хууль”, Усан орчны чанарын үзүүлэлт “Ерөнхий шаардлага” MNS 0899:1992
		Хамгаалатын бүс тогтоож, тоолууржуулж, баталгаажуулах, Сумын БОХУБайцаагчаар усны тоолуурт хяналт хийлгэж акт үйлдэх	Худагт		1	500.000	500.000	БОМ	
3	Хөрсөн бүрхэвч	Уурхайн өрөө тасалгаанд ногоон орчин бий болгох	Уурхайн оффис	Тоо/ш	-	500.000	500.000	БОМ	“Газрын тухай хууль”
4	Газрын хэвлий	Газрын хэвлийд сөргөөр нөлөөлхөөс сэргийлэн тээврийн хэрэгсэлийг замгүй газраар явхыг хориглох тэмдэг самбар байршуулах	Уурхайн бүс, тээврийн замд	-	-	-	-	БОМ	“ургамал хамгааллын тухай хууль” MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Технхикийн ерөнхий шаардлага”
5	Ургамлан нөмрөг	Ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлхөөс сэргийлэн тээврийн хэрэгсэлийг замгүй газраар явахыг хориглох, ажилчидад анхааруулах, ургамлан нөмрөгт мониторинг хийх	Уурхайн бүсэд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	БОМ	
		Өрөө тасалгааг цэцэгжүүлэх	Кемпийн дотор	ш	-	-	1.500.000	БОМ	
		“Тэрбум мод “үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод	Уурхайн бүсэд	ш		500	3.500.000	БОМ	
		Айраг суманд модны суулгац нийлүүлэх	Айраг сумын нутаг дэвсгэр	га ш	4000	500	2.000.000	БОМ	



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын түсгэй зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

6	Амьтны аймаг	МУ-н улаан ном, бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор нэн ховор зэрлэг амьтадын талаарх мэдлэг олгох зорилгоор гарын авлага тараах	Үндсэн болон гэрээт ажилчидад, багийн иргэд	Хүн/тоо	1	1.000.000	1.000.000	БОМ	“Амьтны тухай хууль” “Монгол улсын улаан ном”
		Шувууны үүр хийж байршуулах	Уурхайн бүс орчим	ш	10	100.000	1000.000	БОМ	
		Уурхайн бүсэд байрших ховор амьтанд зориулж усан онгоцонд ус тогтмол байршуулах	Уурхайн бүс орчим	-	-	-	Үйл ажиллагааны зардал	БОМ	
Нийт							11.000.000	0	



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Талбайн дотор байрлах лиценз эзэмшихээс олон жилийн өмнө үүссэн ухаш шороогоор дүүргэх	га	6	583333	3500000	Тухайн жилд -	“Байгаль орчин эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо” MNS5914;2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Тухайн жилд хийгдэхгүй	-	-	-	-		
Нийт						3.500.000		



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
4.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын төлөвлөлт, хэрэгжилт болон шалгуур тавьж хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо нэн чухал юм.	Айраг сумын ЗДТГ-н зааварчилгааны дагуу эзэмшлийн талбайн ойролцоо эзэнгүй орхигдож эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Уурхайн ажилчид, Нард багийн малчин иргэд	1,23 га	731.7	900000	БОМ	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага”-2018 он, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”
Нийт дүн						900.000		



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

7.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Газар чөлөөлж нүүлгэн суурьшуулах асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид төлөвлөгөө хийхийг шаарддаггүй боловч Дэлхийн банкны УАБ/ББ 4.12 –ын шаардлагад нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, ядаж л хамгийн багаар нүүлгэн суурьшуулах хувилбарыг санал болгохыг заасан байдаг. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөж малчин өрхийг нутагшуулах юм.

Төсөл хэрэгжих орчны оршин суугчидын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тусгагдаагүй болно.

8.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

8.1.Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлүүд, “Соёлын өвийг хамгаалах тухай ” хуулийн 38.1.2-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Мин Ли Да” ХХК нь MV-005692 тоот тусгай зөвшөөрөл бүхий 111.97 га талбайд ШУТИС –ийн Геологи Уул Уурхайн сургуулийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвийн доктор Ж.Ундаръяа, доктор Г.Сэрсмаа нарын бүрэлдэхүүнтэй Палеонтологийн хайгуул тандан судалгааны хээрийн ажлыг 2019 оны 06-р сарын 23-24-ний өдрүүдэд хийлгэсэний үр дүнд “Мин Ли Да” ХХК-ны Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Хонгор овоо ” нэртэй MV-005692 тоот тусгай зөвшөөрөл бүхий 111.97 га ашиглалтын талбайд палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлаар эртний амьтан, ургамлан чулуужсан үлдвэр илэрээгүй тул геологийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад палеонтологийн талаас харшлах зүйлгүй гэж дүгнэсэн.

8.2.ШУТИС-ийн БуХС-ийн Археологи-угсаатны судалгааны багийн судлаачид 2019 оны 06 сарын 20-ны өдөр “Мин Ли Да” ХХК –тай байгуулсан гэрээний дагуу 06 сарын 22-23 –ны өдөр хүртэл хугацаанд Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот тусгай зөвшөөрөлтэй 111.97 га талбайд археологийн хайгуул судалгааны ажлыг Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.1-д заасны дагуу хийж гүйцэтгүүлсэн бөгөөд үр дүнд нь төслийн талбайд 4 ширхэг, талбайн



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

гадна талд 26 ширхэг нийт 30 тооны дурсгал илрүүлсэн. Эдгээр нь эртний Хүрлийн үед холбогдох чулуун дараас бүхий булш оршуулгын төрлийн дурсгал хэмээн тодорхойлсон.

Иймд талбайн гадна болон дотор байгаа 30 олдвор нь уг төслийн олборлолт ашиглалтын явцад огтхонч хөндөгдөхгүй байгальд одоо байгаа байдлаараа үлдэх орон зай, талбайд байршиж буй учир талбайн дотор орших 4 олдворыг төслийн үйл ажиллагааны явцад санамсар болгоомжгүй байдлаас хэв шинжээ алдахаас сэргийлж хайс хашаа хийж хамгаалан ажиллах болно.

Түүнчлэн олборлолт ашиглалтын үед түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож сум дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллага, уг асуудал эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Талбайн доторх 4 ш олдворт хайс хашаа хийж хамгаалах	Төслийн талбайд	4	100.000	400.000	БОМ	“Соёлын өвийг хамгаалах тухай” хууль
Нийт					400.000			



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журам мөрдөөгүйгээс гарч болох аваар осол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, осолгүй ажиллах сургалт суртчилгаа тогтмол өгөх	Үндсэн өрийн аюулгүй байдал, э	Хамрагдсан ажилчидийн тоо	-	Үйл ажиллагааны зардал	БОМ	“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай” хууль
2.	Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн ямар нэгэн байдлаар гал гарах үед	Ажиллагсдыг гал гарсан үед авах аюулгүй арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас сургалт авах	Үндсэн болон гэрээт ажилчидад	Хамрагдсан ажилчидийн тоо	1.000.000	1.000.000	БОМ	“Галын аюулгүй байдлын тухай” хууль
3.	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас сургалт авах	Үндсэн болон гэрээт ажилчидад	Хамрагдсан ажилчидийн тоо	1.000.000	1.000.000	БОМ	“Гамшгаас хамгаалах тухай” хууль
4.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журам мөрдөөгүйгээс гарч болох аваар осол	Болзошгүй аваар ослын үед Яаралтай хэрэглэх анхны тусламжийн эм тариа бэлэн байлгах, хугацаа дууссан эм тариаг устгаж шинээр авах	Үндсэн болон гэрээт ажилчидад	Хамрагдсан ажилчидийн тоо	-	1.500.000	БОМ	“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай” хууль



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

5.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журам мөрдөөгүйгээс гарч болох аваар осол	ХАБЭА-н зааварчилгааг тогтмол өгч ажиллах	Үндсэн болон гэрээт ажилчидад	Хамрагдсан ажилчидийн тоо	-	Үйл ажиллагааны зардал	БОМ	“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай” хууль
6.	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшигаас үүсэх хор хохирол	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үндсэн болон гэрээт ажилчидад	1	500.000	500.000	БОМ	“Гамшигаас хамгаалах тухай хууль”
7.	Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн ямар нэгэн байдлаар гал гарах үед	Галын аюулгүй байдал хангаж, Галын дүгнэлт гаргах	Үндсэн болон гэрээт ажилчидад	1	500.000	500.000	БОМ	“Галын аюулгүй байдлын тухай” хууль
Нийт						4.500.000		



11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уг төслийн хүрээнд ахуйн шингэн хог хаягдал, хатуу хог хаягдалыг байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бага байхаар хог хаягдалын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан ба хог хаягдалыг цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, зөөж тээвэрлэн хаях гэсэн аргуудыг сонгон ашиглаж байна.

Ахуйн гаралтай хог хаягдал

Уурхай нь тухайн онд 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллана. 1 хүнээс хоногт 0.3 кг энгийн хог хаягдал /Дэлхийн эүүл мэндийн байгууллагын судалгаагаар хүн хоногт 0.290 кг ахуйн хог хаягдал ялгаруулж хаядаг гэсэн тооцоо байдаг/ гэж тооцоход сард 180 кг, улиралд 540 кг хог хаягдал гарна гэж тооцов.

Хатуу хог хаягдал

Техник хэрэгсэлүүдийн сэлбэгийн хаягдал төмөр, дугуйны хаягдалыг цуглуулан түр цуглуулах цэгт ангилан байршуулж төмрийг хаягдал төмөрт тушаана, дугуйг хашаа хороо хийх малчин өрхүүдэд өгөх зэргээр дахин ашиглах байдлаар зохицуулалт хийнэ.

Аюултай хог хаягдал

Шатах тослох материалын хаягдал, ашигласан тос масло зэргийг технологийн дагуу битүү саванд цуглуулан хадгална. Дүүргэлтээс нь хамааруулан Хэнтий аймгийн Бор-өндөр суманд байрлах баяжуулах үйлдвэрт хүргүүлнэ.



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Хог хаягдалын гэрээг Айраг сумын ЗДТГ-тай хийж сумын нэгдсэн хогийн цэгт зөөж тээвэрлэн хаях	Айраг сум	улиралд	1200.000	1	1200.000	БОМ	Монгол улсын “Хог хаягдалын тухай хууль”, МХГ-ын “Хог хаягдалын ангилан ялгалтын зааварчилгаа”
		Хог хаягдалаар хөрс бохирдохоос сэргийлж бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Уурхайн бүсэд	улиралд	-	-	Үйл ажиллагааны зардал	Улиралд 1	
		Хогийн цэгийн ангилан ялгалт бүхий хаяг хийж байршуулах	Уурхайн бүсэд	ш	150.000	3	450.000	БОМ	
		Хог хаягдалыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших, гарын авлага тараах	Уурхайн бүсэд	ш	500.000	1	500.000	2,3-р улиралд	
2.	Үйлдвэрийн	“Хог хаядаггүй соёлтой ажилтан” сарын аян зохион байгуулж ажилчдад хог хаягдалын талаар мэдлэг олгох	Уурхайн бүсэд	-	500.000	1	500.000	2-4р улиралд	
3.	Аюултай	Хог хаягдалын цэгийг хаягжуулж битүүлэх,	Уурхайн бүсэд	-	700.000	1	700.000	2-р улиралд	
	Нийт						3.350.000		



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1.	Хөрс:хүнд метал, хими физик,бакт ерлоги	-Хог хаягдалын цэг-1 -Засварын цех-1 -Далд уурхайн ам-1	2,3-р улиралд	2	56900	341400	Хөрс хамгийн их бохирдож болзошгүй цэгүүд	Хөрс шинжилгээний дээж авхад тавигдах ерөнхий шаардлага MNS 3298;1991
2	Ус: хүнд метал, хими физик,бакт ерлоги	-унд ахуйн хэрэглээний усны зөөврийн худгаас-1 цэг -ундны усны шүүлтүүрийн -1 цэг -зөөврийн усны машин-1 цэг	2,3-р улиралд	2	46500	279000	Ундны усны цэгүүд	Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900;200 Монгол улсын “усны тухай хууль” MNS 0900;2018
3	Агаар, Тоос:азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоос, рm-2.5, рm-10	-Уурхайн салхины чиглэл доор -1 цэг -засварын талбай-1 цэг -Уурхайн тосгон-1 цэг	2,3-р улиралд	2	33600	203600	Уурхайн үйл ажиллагааны улмаас тоосжилт нэмэгдэх эсэх	Монгол улсын агаарын чанар, терникийн ерөнхий шаардлага MNS4285;2016 Монгол улсын “Хөрсний тухай хууль”
4	ОХШ-ний сорьц авч ажиллах ажилтны томилолт, хоол, унааны зардал					400000	Шинжилгээний мэргэжилтэнг уурхайд ирэх, хүргэж өгөх зардал	
Нийт						1224000		



13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2020 он				
			Сар 10	Сар 11	Сар 12		
1	2	3	4	5	6	7	
1.	БО-ны мэргэжилтэнг ажиллах нөхцөл бүрдүүлж зөөврийн компьютерээр хангах	3.000.000	10	11	12	Гүйцэтгэх захирал, Уурхайн дарга	Боловсон хүчинг тус чиглэлээр мэргэшүүлэх, дэмжин суралцуулах, уурхайд тогтмол байрших 2
2.	БО-ны мэргэжилтний туслах ажилтны орон тоог уурхайд байрлах 2 ажилтанаар батлан ажиллуулах	Үйл ажиллагааны зардал	10	11	12	Гүйцэтгэх захирал, Уурхайн дарга	туслах ажилтангаар ажиллуулах бөгөөд цалингийн зардалыг компанийн дотоод журмаар зохицуулна. Хууль эрх зүйн хэм
3.	БО-ны үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг хууль эрх зүйн хэм хэмжээнд дэмжин ажиллах	Үйл ажиллагааны зардал	10	11	12	Гүйцэтгэх захирал, Уурхайн дарга	хэмжээнд дэмжин ажиллах зардалыг уурхайн удирдлага нь хариуцан ажиллана.
4.	Байгаль орчны аудит мэргэжлийн байгууллагаар хийлгэх /2 жил тутамд/	Гэрээний үнийн дүнгээр	БОМ төлөвлөгөөний хугацаанд			БОМэргэжилтэн, Уурхайн удирдлага, Захиралууд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, “Байгаль орчны
5.	БОННУ –г мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гэрээний үнийн дүнгээр	БОМ төлөвлөгөөний хугацаанд			БОМэргэжилтэн, Уурхайн удирдлага, Захиралууд	аудит хийх ерөнхий аргачлал”, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт		3.000.000					



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023он

14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	2023 оны БОМТ-г хүргүүлэх, батлуулах	БОМТ-нд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн талаар	БОМТ	400.000	Компаний удирдлага, Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн, бусад инженер техникийн ажилчид	Хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамааран Айраг сум ба уурхайуун бүсэд зохион байгуулна.
2	Айраг сумын ЗДТГ, ИТХ, Багийн засаг дарга	2023 оны БОМТ –г хүргүүлэх			50.000		
3	Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	2023 оны БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэл тайланг тайлагнаж дүгнүүлэх			400.000		
4	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэд	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гарсан санал гомдолыг шийдвэрлэх			Тохиролцсон үнийн дүнгээр		
5	Багийн засаг дарга, багийн иргэд болон ард иргэдийн төлөөлөл	БОМТ-ний биелэлтийг тайлагнах			800.000		
6		Нард багийн малчин иргэдэд экологийн боловсрол олгох гарын авлага тараах			800000		
Нийт					2.450.000		



Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жонш”-ийн ордын төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023 он